

**МОНГОЛ ХААДЫН УГСАА ЗАЛГАМЖЛАЛ:
АЮУШРИДАРААС (1338-1370-1378) ЛИГДЭН ХУТАГТ
(1592-1604-1634) ХҮРТЭЛ**

ДУГАРСҮРЭНГИЙН ЭНХЦЭЦЭГ
МУИС -ийн Түүхийн тэнхимийн зөвлөх дэд профессор

Хураангуй: Эзэнт гүрний дараах үе - Аюушридараас (1338-1370-1378) Лигдэн хутагт (1592-1604-1634) хүртэл Чингис хааны угсааны Алтан ургийн хаадын угсаа залгамжлалыг тодруулах анхдагч сурвалж хэрэглэгдэхүүн хомс, хожмын түүхэн зохиолуудын мэдээ зөрүүтэй, судалгаа цөөн, олон асуудал анхаарал татсан хэвээр байдаг. Хаадын угсаа залгамжлал, хаан суусан он цагийн зөрүүг тодорхой болгохын тулд Монголын түүхийн зохиолуудын мэдээг Хятадын албан түүхийн он цаг лугаа харьцуулан нягтлах явдал чухал юм. Сурвалж болон судалгаанд тухайн үеийн хаадын угсаа залгамжлалд он цагийг зөрүү гарах болсон нэг шалтгаан нь Монгол дахь хоёр засгийн үе юм. Мөн Тодобух [Тайсун]-ын хүү Махагүргис (1446 -1454-1464) хаанд холбогдох он цагийн зөрүү хаадын угсаа залгамжлалыг бүрхэгдүүлж, он цагийн ялгаа буй болгожээ. Махагүргис хааныг нэг он хаан суусан гэх мэдээг баримтлан Батмөнх Даян хааны төрсөн болон хаан суусан, тэнгэр болсон он тооллыг зөрүүтэй тэмдэглэдэг. Үүнээс улбаалан Боди Алаг хааны түүхэн хэрэг явдлыг он цагийн хувьд зөрүүтэй тэмдэглэж иржээ. Энэ бүхнийг нягтлан Монгол хаадын угсаа залгамжлалын түүхийг авч үзсэн болно.

Түлхүүр үг: Угсаа залгамжлал, хаанчлал, Монгол дахь хоёр засгийн үе, Махагүргис хаан,

Төвлөрсөн удирдлагатай, асар их нэр хүндтэй, аливаа эсэргүүцлийг олон түмний дэмжлэгтэй давж чадах хүчирхэг төрт ёс бол дорнын төр юм. Хүчирхийлэл, дарангуйлал, цэрэг цагдаагийн хүчээр бус олноос онцгойрон, улс орноо удирдах чадварыг үйл ажиллагаагаар харуулсан хааны нэр хүнд, олон түмний итгэл хоёрын шүтэн барилдлагаар Монгол улсын төр тогтож ирсэн түүхтэй.

Он цаг улирахын хэрээр эрхэм дээд Хаан хүмүүн - номонд төгс, тэрхүү номын ухаанаар төр улс, ард олноо гэгээрүүлэн жолоодох ухаан хүрдэн эрдэнэ; бүхний сэтгэлийг өв тэгш бүрнээр татах чадварыг эзэмшсэн чандмань эрдэнэ;

халамжит сайн, үнэнч хатан эрдэнэ; хамтын ухаанаар улс орныг удирдах зөвшилцөх шудрага түшмэл эрдэнэ; туйлбартай тэвчээртэй, аливаад тууштай заан эрдэнэ; дайчин зөвшингүй эрмэлзлэл тэмүүлэл дүүрэн хийморьлог морин эрдэнэ; башир хуурмаг зангүй, сүр хүчтэй олонд хүндтэй ноён эрдэнэ мэт төгс эрдэнийн шинжийг бүрдүүлсэн хаад үгүй болж, мэргэшсэн улс төрч, төрийн тэргүүнийг бэлтгэх бодлого улирч оджээ. Хаан төр сонгодог утгаа алдан түүнийг үл хүндлэх, үл бишрэх, үл итгэх явдал нэмэгдсээр засаг төр доройтон, засаглалын хямрал, задрал бутрал үүджээ.

Юань улсын ноёрхол халагдан хаант төр уугуул нутагтаа шилжин, монголчууд дэлхийн түүхийг идэвхитэй бүтээлцсэн эрин үе ард хоцорч, төр улсыг удирдах хааны хүч чадал, эрх мэдэл, нэр хүнд сулран, ноёд язгууртны эдийн засаг, цэрэг улс төрийн бие даасан байдал бэхжин, дотоодын зөрчил тэмцэл, засаглалын хямрал улс орны үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх болов. Энэ талаар анхдагч монгол хэлний сурвалж хэрэглэгдэхүүн бидний үед хүрч ирсэнгүй, хожмын түүхэн зохиолуудын мэдээ нь хоорондоо зөрүүтэй, судалгаа цөөн бөгөөд энэ үеийн олон асуудал анхаарал татсан хэвээр байдаг. Хэдийгээр улс төрийн задрал бутрал үргэлжлэн, улс орны амьдрал ээдрээтэй байсан ч Аюуширідараас (1338-1370-1378) Лигдэн хутагт (1592-1604-1634) хүртэл Чингис хааны угсааны Алтан ургийн хаад Монгол улсын төрийг үе улиран залгамжилжээ. Эзэнт гүрний дараах үеийн Монголын төр хэлбэрийн хувьд хаант, эрхийн талаар хязгаарлагдмал шинжтэй байж, хэмжээгүй эрхэт хаант засаг зарим үед сонгодог утгаараа хараахан үйлчилж байсангүй. Тийм боловч 300 орчим жил хасбуу тамгыг атгасан Алтан ургийн Толуйн угсааны 19, Аригбухын удмын нэг, Өгөдэйн угсааны нэг хаан, өөрийгөө хаан хэмээн өргөмжилсөн Хасар угсааны нэг, Ойрад угсааны хоёр нийт 24 хүний нэр үйл хэрэг, алдаа оноо түүх сударт тэмдэглэгдэн үлджээ. Эзэнт гүрний дараах үеийн Монголын түүхийн хэрэг явдал, хаадын угсаа залгамжлал, он цагийн зөрүүг судлахад анхдагч хэрэглэгдэхүүн болох монгол сурвалж зохиолуудын мэдээ, он цаг, түүхэн үйл явдлыг хятадын албан түүхтэй харьцуулан, магадлан нөхвөрлөх боломжтой байдаг.

ХОЁР ЗАСГИЙН ҮЕ (1403 - 1438 он)

Сурвалж болон судалгаанд тухайн үеийн хаадын угсаа залгамжлал он цагийн зөрүү үүсч гарах болсон нэг шалтгаан нь Монгол дахь *хоёр засгийн үе* юм. Улс төрийн амьдрал хамгийн ээдрээтэй тэр цагт хоёр засаг тогтдог ёсон хүн төрөлхтөний түүхэнд ч, Монголд ч цөөнгүй тохиолдож байв. Улс орны амьдралд зөрчил тэмцэл гүнзгийрэн, аливаа мөргөлдөөнийг улс төрийн зөвшилцөл, тайван замаар шийдвэрлэх, сэргийлэх боломж хомсдож, дайн тулаан олширсон 1400-1440 оод онд Алтан урагт хаадын төр засгийн сүр хүчин хамгийн их доройтсон үе байв. Монголын түүхийн зохиолуудад Бунышири [Өлзийтөмөр], Гүйлич, Дэлбэг, Ойрадай, Адай, Ажай тайж, Тайсун хаад ширээ залгамжилсан тухай,

тэдний угсаа гарвал, үе залгамж, төрсөн, хаан суусан, тэнгэр болсон зэргийг товчхон дурьдаж, тэдний үйл ажиллагааг дэлгэрэнгүй өгүүлсэн мэдээ сэлт ховор, зөрөө ихтэй тул зарим судлаач *Монголыг хэд хэдэн хаан удирдаж* ¹байсан гэх санааг дэлгэрүүлэн судалжээ.

1402 онд Аругтай [зарим нь Үгэчи хашиха гэх], Гүйличийг тэтгэж хаан ширээнд суулган эрх мэдлийг төвлөрүүлэхийг оролджээ. Гүйлич бол Мин улсын магад хуульд Хун Ү-гийн 23 онд Мин улсын хуандигаас [11 хүнд хаягласан²] Монгол ноёдыг дагаар ирэхийг уриалан ухуулсан бичигт нэр тэмдэглэгдсэн нөлөө бүхий хүн байв. Саган Сэцэн, Гүйлэч бол Гүнтөмөрийн дүү Өлзийтөмөр гэсэн бол Шар туужид Элбэг хааны их хөвгүүн Гүнтөмөр ... дүү нь Өлзийтөмөр³, Шмидт Өлзийтөмөр бол Гүйлич, Ховард болон зарим судлаачид Ойрадын түрүү Өгжхашиха мөн⁴, Киргиз аймгийн тэргүүн, Өгөдэйн хойчис, Аригбөхийн хойчис; Д.Покотилов Ховардтай санал нийлэхгүй байгаагаа илэрхийдээд Гүйлич бол монголын олон ноёдын нэг, төрийн эргэлт хийсэн хүн⁵ гэх адил бус таамаглал байдаг. Гүйлэч бол Буяншири [Өлзийтөмөр] биш болох нь явуулж байсан үйл ажиллагаа, тэдний хоорондын харилцаа зэргээс тодорхой. Намсрай түүнийг Аригбөхийн хойчис, Мин улсын Магад хуулийн мэдээг үндэслэн Буянхүү нар Гүйлич бол Өгөдэйн хойчис, эзэмшил нутаг нь Ганьсу орчмоор нутаглаж байв гэж үздэг. Жахачидай Буяндэлгэр: түүний гарал Өгөдэйн хойчис болохыг тодруулан “...завшааныг ашиглан Төгстөмөр хааны хуучин түшмэл Аругтай зэрэг хүмүүс шинэ хаан өргөмжлөхдөө ... Ойрадтай таарамж муутай Гүйличийг сонгожээ. Гүйлич ийнхүү онцгой цаг үед Зүүн Монголын хаан ширээний сул орон зайг нөхвөрлөж байв ... Гүйличийн өвөг дээдэс Хадаган болон Юань улсын сүүл үед урвасан Ян Ди ван Аргунтөмөрийн өвөг дээдэс Мээлэг нар цөм Өгөдэйн бага хатан Эркинагаас төржээ. Тэд Өгөдэйн хөвгүүд дунд байр сууриараар доогуур байсан ... Монголын их хааны ширээ Тулуйн угсааныханд шилжих үед гэр бүлээрээ Мөнх хааны талд оржээ. Ширэмүн зэрэг хүмүүсийг дарсны дараа Мөнх хаан Өгөдэйн эзмшлийг хэдэн хэсэг хувааж, Өгөдэйн үр ач нарт эзэмшүүлжээ ... Хадаганы хувь Бишбалигт [Бэшбалыг], Мээлэгийн хувь [эзэмшил] Эрчис мөрний сав газар байсан ба тэр хоёрын нутаг залгаа оршиж байв. Хадаган, Мээлэг нар ... Өгөдэйн удмынхны төлөөлөл хэмээн Юань улстай нягт харилцаатай байжээ. Иймээс Юань улсын сүүл үеийн Аргунтөмөрийн хүчирхэгжилт хийгээд XV зууны эхэн үеийн Гүйличийн харьяаныхны сэргэн мандалт нь бүгд гэнэтийн зүйл биш юм. Гүйличийнхний харьяат нутаг Хами,

¹ Грумм Гржимайло. *Западная Монголия и Уринхайский край*, том II, Л., 1926, 579; Буяндэлгэр. XV зууны эхэн хагасын Умард Юань улсын хаадын угсаа залгамжлал ба төрийн байдал//АСТА HISTORICA MONGOLICA. Том XIX. F-66, УБ., 1919, 69; Д. Энхцэцэг. Хаант төрийн хямрал, хоёр засгийн үе (1403-1438 он)//*Түүхийн судлал*. Tomus XLVIII. Fasc. 1-29. УБ., 2019, 92-105.

² Ариунгуа Н. *Монголын түүх ба Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд (XIV-XVI)* УБ., 2022, 48.

³ *Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. VII. УБ., 2006, 62.

⁴ *Монгол улсын түүх*. Гутгаар боть. УБ., 2004, 42.

⁵ Покотилов Д. Д. *История восточныхъ монголовъ въ периодъ династiи Минъ*. 1368 - 1634. по китайскимъ источникамъ. СПб., 1893, 33.

Ганьсугийн хилийн гадна (одоогийн Алшаа, Эзнээ нутаг) байсан. Гүйлич, Хамигийн ван Энхтөмөрт хор идүүлж алжээ. Зүүн Цагаадайн хаан Сами цагаан цэрэг удирдаж Гүйличээс ял асуув. Гүйлич хуучин нутаг Бишбалыгийг алдаж, хожим нь Хамигийн орчим нутгийг булаалдах дайнд [хүч нь дорой болжээ] ... Аругтайг дагаж зүүн тийш шилжсэн”⁶ тухай өгүүлжээ.

Мин улсын түүхэнд ... Гүйличи гэгч этгээд хаан суурийг булаан авч, хаан хэмээн нэрлээд улсынхаа нэрийг гэж Татаар хэмээжээ, Гүйличи хаан ширээ булаан авмагцаа [Юань хэмээх улсын цолоо халж–Д.Э] өөрийгөө ... [Их хаан], улсын нэрийг хуучнаар Дадань [Татар] хэмээн нэрлэв ⁷ хэмээн бичдэг.

Мөн хожим Ваньли хааны тэмдэглэлд ...[Г]үнтөмөр нас барж, Гүйличи их ор суув. Гүйличи Юань улсын их хаадын удмын хүн биш. Шуньди [Тогоонтөмөр] хаанаас Гүйличи хүртэл долоон үе өнгөрсөн байна. Учир иймд түүний харьяат нарын олонхи нь урвав. Гүйличи тай бао Алутай [Аругтай], чжи юань Алутөмөр, тай вэ Наэрбухао нарыг түшиглэн харьяат[аа] түвшитгэж самууныг төгсгөл болгов. Гэтэл тайш баруун гарын чэнсян Мартайхайза тайфу, зүүн гарын чэнсян Есуньтэй нар болон Ойрад бас цэргийн эрхийг гартаа авч үлэмж хүчирхэг болоод хааны захиргааг хүлээхгүй болов. Хаан яах ч аргагүй болов. Тэр жил Чзянь – вэнь (1399 -1402) -ний III [1402] он юм ⁸ гэжээ.

Гүйлич (?–1402-1408) Монголын их хааны суурийг эзэлж, баруун гарын чинсан Мархасан, зүүн гарын чинсан Эсэнтэй, түшмэл Аругтай нарыг томилж төрийн хэрэг эрхлүүлж, Мин улсын хаанд элч илгээн харилцаж байв. 1403 онд Мин улсын Юунлө (永樂)(1403–1424) ширээнд суумагц Монголын хаан болон Ойрад, Урианханы ноёдод тус тус элч илгээж улс орны амьдралд хөндлөнгөөс оролцож эхэлснээр Мин болон Монгол хаадын элч харилцаа сэргэжээ. Тухайлбал:

Юунлө (永樂)(1403-1424) - гийн тэргүүн он. Хаврын дунд сард Гүйличийн илгээсэн элчийг нэвтрүүлэхийг зөвшөөрөн, элч илгээн сайнаар харилцахыг аргадан ухуулж, мөнгө торго шагнаж, түүний жыюань Аругтай, чөншян Мархасан нарт бас [шан харамж] шагнаж ⁹ хариу захидал илгээж ... Мин улсын төрөөс холын хүнд ёс журамтай хандана ... эдүгээ тэнгэрийн доорхи байдал нэгэнт тогтнов. Ойр хавийн улсууд цөм биднийг дагажээ. Хаан та элч илгээж, харилцвал бид бүгдээр нэг гэр болж, хилийн хот суурин дайн дажингүй, харилцан эв найртай, хамтдаа амар тайвныг эдлэе ¹⁰ гэж ятгажээ.

⁶ Буяндэлгэр. XV зууны эхэн хагасын Умард Юань улсын хаадын угсаа залгамжлал ба төрийн байдал//ACTA HISTORICA MONGOLICA. Tom XIX. F-66, УБ.,1919, 69.

⁷ *Мин улсын судар. Олон шиштур.* 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018,134; Мин улсын түүх. УБ., 2015, 21.

⁸ Цю Цзюсы. *Дунд гурван хилийн монгол ван тайж нарын намтар.* УБ., 2011, 18.

⁹ *Мин улсын судар. Олон шиштур.* 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 135.

¹⁰ 明太宗实录(Мин Тайзун шилү), 永乐元年正月己未、七月庚寅,三年十二月乙亥 (Юунлөгийн тэргүүн оны нэгдүгээр сарын шарагчин хонь өдөр; долоон сарын цагаан бар өдөр; гуравдугаар оны арван хоёр сарын хөхөгчин гахай өдөр)

Гүйлич, Мин улсын элчийг барьж хориод Мин улстай харилцсангүй тул 1406 оны гурван сард Хашин нарыг илгээж, элчийг хорьж байгааг сануулж, нэгэн гэр бүл мэт эв найртай байх дахин уриалжээ. 1407 онд Мин улсын түүхэнд тэмдэглэсэнээр ... удаа дараа элч томилон бичиг илгээлээ. Гэвч та элчийг буцаасангүй, эдүгээ ч Бай Ху, Зо Хув нарыг томилон, учир шалтгааныг олж ... дээд тэнгэрт мэдэгдэхийг хүсч байна. Хаан та тунгааж үзнэ үү ¹¹ хэмээжээ. Нийт таван удаа элч илгээсэн ч Гүйлич хариу ирүүлсэнгүй гэх.

Харин Мин улсын магад хууль-д ... Татарын лам [耳亦赤, 也儿吉你儿] [элч] нарыг буцааж, Ойрадын тайш, баруун гарын чинсан Марханза ба толгойлогч Тохочи нарт эд мөнгө хүргүүлэв, хилээс гартал нь хамгаалав. Гүйличийн хүн [элч-Д.Э] хэлэхдээ ... Гүйлич баруун тийш Ойрадыг дайлах санаатай, гэрийн хүмүүсээ өмнө зүгт нүүлгэх гэтэл хилийн цэрэг ноёд дайлахаас айж байна, хүн томилон, цэрэг ноёд дайлахаар мордохыг [үл] алгуурлах тухай, Гүйлич бууж өгөхийг бодож байгаа ч шийдэж чадахгүй байна. Иймээс хүн томилон төр засгийн санааг тандаж байгаа нь энэ [бололтой] ¹² хэмээсэн нь Гүйлич Мин улстай элч илгээн харилцаж байсан баримт болно.

Гүйлич, хаан суурийг авсан ч монгол ноёдын дэмжлэгийг олж чадсангүй. Үүний шалтгааныг Мин улсын магад хуульд Их Юань улсын угсаа биш [Хубилайн хойчис бус] хэмээснийг үндэслэн Дай хуни, Буян нарын зүгээс Гүйлич бол Үгэчи хашиха биш, Өлзийтөмөр ч бус, тэрээр Өгэдэйн хойчис, баруун, зүүн монголын ноёдын дэмжлэгийг олж чадаагүй гэж үзсэн. Монголчуудын хямрал зөрчил хурцдан Юунлөгийн III [1405] онд [зуутын дарга] Тоуму, Саохур Цагаан, Далаху зэрэг [ноёд] хойно хойноосоо ирж [Мин улсад] бууж өгөв. Монголын дотоод зөрчил удаан үргэлжилж ойрадууд, Аругтай нарын хүчийг Хэрлэн голын цаана хүртэл түржээ. 1408 оны таван сард Ойрадын Батула чэнсян [хятад сурвалжид Махаму гэх] нар хүч хавсран довтлоод [Гүйличийг хороож ¹³]; Гүйлич аймаг олноо дагуулан Ганьсу орчим нутагтаа ¹⁴ буцаж, удалгүй нас нөгчсөн гэнэ. Гүйличийг хаан ширээг хууль бусаар булаагч гэж Шмидт бичсэн бол хаан ширээ залгамжлах эрхгүй гэж Delamirг үзсэн байдаг. Харин Грумм Грижимайло түүний үйл ажиллагааг *Гүйличийн шинэчлэлт* гээд засгийн эрхийг хууль бусаар булаасан Хубилайн угсаа залгамжлалыг өөрчлөхийг оролдон, Юань нэр, династыг халж, урьдын *Татар* буюу *Монгол улс* нэрийг сэргээхийг оролдсон ¹⁵ гэжээ.

Монгол, Ойрадын хямралын үед Элбэг хааны хүү Бунышири [Өлзийтөмөр] Дундад Ази, Цагаадайн улсад очиж хүн ард, цэрэг морио амраан [Мин шилү-д

¹¹ 明太宗实录(Мин Тайзун шилү), 永乐四年三月辛丑,五年五月丙寅、十月壬辰 (Юунлөгийн дөрөвдүгээр оны гурван сарын цагаагчин үхэр өдөр;тавдугаар оны таван сарын улаан бар өдөр;арван сарын хар луу өдөр)

¹² Монгол - Мингийн элчийн харилцааг судласан нь (明蒙通使探析) Гү Рүма (姑如玛), 2005, 19.

¹³ *Мин улсын судар. Олон шиштур*. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 136.

¹⁴ Дай хуни, Буян. *Умард Юаний түүх*. ӨМСХХ., 1991, 80.

¹⁵ Грумм-Грижимайло. *Западная Монголия и Уринхайский край*. Том II. Л., 1926, 575-576.

... эхлээд Самаркандад байж байгаад Бишбалык руу зугатсан тэнд түүнийг хаан ширээнд өргөмжилсөн зэрэг мэдээ байна¹⁶) Бэшбалыгт түр суужээ. 1403 онд Цагаадайн улсын Доголон Төмөр эмир (1370-1405)-ийн дэмжлэгтэй Монголын хаан хэмээн өргөмжлөгдөж, *Юаний үр удмын Буянширийг Бишбаликт хаан ор суулгав* ¹⁷хэмээн тэмдэглэгджээ. Ийнхүү 1403 оноос Гүйлич (? -1402 - 1408) болон Буяншири [Өлзийтөмөр] (1379-1403 -1410) *хоёр хаан сууж* засаглалын хямрал туйлдаа хүрчээ. Гүйлич, Буяншири хаанд элч илгээн түүнийг Алтан ургийн хойчис хэмээ[гээд]... [Монгол нутагтаа ирж] хаан суурийг залгамжлахыг зөвлөж байв.¹⁸ Доголон Төмөр эмир, Буянширитай хамтран Мин улсыг цэрэглэн мордохоор завдаж байгаад 1405 нас эцэслэсэн тухай мэдээг илүү тодруулах баримт олсонгүй.

Юунлөгийн зургаадугаар оны [1408] нэг сард Мин улсаас тайган Ван Ань нарыг томилон [Бэшбалыгт] Буянширт илгээсэн бичигт ... хэрвээ бодлоо өөрчилж дагаж ирвэл цол зэрэг, эд хөрөнгө шагнана, ойрхон сайн газрыг шилж, амьдарч болно¹⁹ гэжээ. Гэвч хариу илгээсэнгүй.

Мин улсын түүхэнд тэд хятадын хилийг уулгалах гэж байгаа болон хуанди Бишбалык руу туршуул явуулах талаар ... Ганьсугийн цэргийн эрхтэн Хэфуд Хами руу адуу авах нэрээр хүн илгээж Буянширийн байдлыг тагнан мэдэх зарлиг буулгаж... [мөн [Юунлөгийн VI он] 1408 онд түүнд илгээсэн захидалд] Самаркандаас ирсэн мэдээнээс үзэхэд өөрийг чинь Бишбаликт амьдарч байна ²⁰ гэж сонслоо. Гүйлич чамайг тосон угтахаар явсан гээд түүнээс болгоомжилохыг сануулжээ. 1408 оны арван сард Асуд аймгийн Аругтай ноён, Буянширийг угтан авч, Өлзийт цолтой хаан ширээнд өргөмжлөн, Аругтай ²¹ улсын тайш болж, хаан төр дахин нэг удаа нэгдэх боломж бүрджээ. Буяншири [Өлзийтөмөр] хаан ²² цэрэг, улс төрийн хүчийг зузаатган

¹⁶ Ариунгуа Н. *Монголын түүх ба Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд (XIV-XVI)* УБ., 2022, 62.

¹⁷ Мин улсын түүх. УБ., 2015, 21.

¹⁸ Дай хуни, Буян. *Умард Юаний түүх*. ӨМСХХ., 1991, 79-80.

¹⁹ 明太祖实录(Мин Тайзун шилү)永乐六年正月甲子、三月辛酉(Юунлөгийн зургаадугаар оны нэг сарын хөх хулгана өдөр; гурван сарын цагаагчин тахиа өдөр)

²⁰ Ариунгуа Н. *Монголын түүх ба Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд (XIV-XVI)* УБ., 2022, 62.

²¹ Асрагч нэртийн түүх зэрэг Аругтай тайш, уг нэр нь Өөдлөх, Батула чинсанд баригдаж, араг үүрч аргал түүх болсноор Аругтай нэрийг олсон гэдэг. Гүйлич ноёныг хө[n]өж Өлзийтөмөрийг хаан ширээнд өргөмжлөн, өөрөө тайш болсон. Хожим Адайг тэтгэж хаан ор суулгажээ. 1434 онд Тогоон тайшийн гарт нас нөгчжээ.

²² Элбэг хааны хүү Шар тууж, Асрагч нэрийн түүх зэрэгт Өлзийтөмөр, [Хураангуй алтан товч, Лу Алтантовч зэрэгт *Улүйтөмөр, Улүйтөмөр, Элтөмөр,*] [Мин улсын түүхэнд Буяншири гэжээ] шаргачин хонин жил буюу шороон хонин [1379] жилтэй, 25 наснаа харагчин хонин [1403 он] жилд хаан сууж, найман [гурван жил, есөн жил, арван гурван] жил сууж, 32 -ныхоо цагаан барс [1410 онд] [Гангын урсгалд зэрэг зарим сурвалжид гал гахай жилд гэх] жилд халив гэж бичсэн байдаг. Махаму Буянширийг довтлон хороожээ гэж Мин улсын түүхэнд Юунлө (永樂) (1403 – 1424)- гийн XX [1412] онд мэдээ үлджээ. Хожмын монгол түүхийн зохиолуудад найман он хаан суув гэдэг нь 1403 оноос тоолон 1410 онд нас барсан гэвэл найман он, монгол нутагтаа ирсэн 1408 оноос эхлэн 1410 он хүртэл гурван он гэж тоолдог байна. Перс сурвалжид түүнийг Өлзийтөмөр болон Огул хэмээх нэрээр гарах бөгөөд Аригбөхийн удам, Мин улсын түүхэнд Юаний [хаадын] угсаа гэжээ.

Ойрадад, дараа жил нь Урианханы гурван харуулын удирдагчидад элч илгээж, нөлөө байр сууриа бэхжүүлж байв. Гэвч Мин улсын цэргийн довтолгоо цаашдын үйл хэрэгт саад учруулах болсон. Юунлө хуанди, Бээжинд шинэ орд харш байгуулан, Нанжингаас Мин улсын нийслэлийг шилжүүлсэн нь монголчуудтай харилцах, улс төр дипломатын болон цэрэг дайны бодлогоо хэрэгжүүлэхтэй шууд холбоотой.

Мин улсын түүхэнд ... энэ жил [1408 он] Гүйличи доорхи хүмүүндээ алагдахад Буняшири хаан болов²³, [Мин улсын Юунлө (1403-1424) хуанди] ... Аюушридара умарш шилжсэнээс эдүгээ ... таны ард түмэн хуяг дуулга биеэс салгахгүй, нум хутгаа гараасаа салгахгүй зүүн баруунд нэхэн шилжээд, хөгшид үл жаргаж өсвөр багачууд нь амар түвшин(гүй) хэдэн арван жил болов хэмээн VI [1408] оны хавар Өлзийтөмөрт захидал хүргүүлэв... Юаний цэрэг мөхөж, Шуньди [Тогоонтөмөр] хаанаас хойш Аюушридараас Гүнтөмөр хүртэл зургаан хүн түргэн түргэн ха[а]н ор сууж, сонсохноо өөрийн үхлээр нэг ч үхсэнгүй. Миний өвөг дээдэс Мин Тайзү хаан ... Юаний үр садыг онцгой анхааран ивээлдээ багтаан дэм үзүүлж байв. Бууж өгөгсдийг ... зарлиг буулган буцаав ... миний сэтгэл өвөг дээдсийн сэтгэлийн нэгэн адил билээ. Өнөө Юанийхан өвөг дээдсийн ариун ёсыг утас лугаа таслах эсэх нь жаргал зовлонгийн шалтгааныг ялган салган ухаарснаас хамаарах тул үүнийг сайтар тунгаа ²⁴ хэмээн ятган элч илгээжээ. Буняшири хаан хариу илгээсэнгүй.

Дайн тулаан олширч, Буняшири [Өлзийтөмөр] хаан, Аругтай тайш нар Батула [Махаму]-гийн цэрэгт ялагдан, зүүн зүгт Хэрлэн гол [Лючү] руу шилжин суужээ. Дайн тулаанаас зугатсан хааны харьяат хүмүүс [22 хүнийг олзлов] Мин улсад зугатан очсон байна. Буняшири [Өлзийтөмөр] хаан суусныг эсэргүүцэн зарим хүн Мин улсад дагаар орсон гэжээ

VII оны [1409] зуны сүүл сарын цагаагчин гахай өдөр Мин улс Гуо Жы-г [Буняширид] [элчээр] илгээж, хил сахигч жанжин ... [хаан] таны хараат зэрэг 22 хүнийг олзлов. Тэдний хэлэхээр чамайг нэгэнт хаан ор суулгажээ гэнэ. Чи элч илгээж эвсэхийг хүсэж байвал, мөхөс миний сэтгэл маш их баясна ... хаан та үнэнчээр дээд тэнгэрийн санааг дагаж, доод хүний ертөнцийн явдлыг нягталж элч илгээн найрамдалтай харилцаж, мөхөс би Дундадыг мэдэж, хаан та Говь нутгаа [Монголыг-Д.Э] мэдэж, харилцан өнө үүрд халдахгүй байвал сайн биш үү?²⁵ гэжээ. Буняшири саналыг хүлээн авсангүй. Гоу цзи [Гуо Жы нэрт][элчийг] илгээв ... түүнийг барьж алаад бас хариу өгсөнгүй.²⁶ Юунлөгийн санаархал талаар болов. Буняшири хаан, Аругтай тайш нар Ойрадтай тулалдаад амжилт олсонгүй, Хэрлэн голд буцсан үед Мин улсаас Буняширид элч томилж, [олзлогсодыг] ... нарыг буцаан, эвсэхийг хүссэн ч та нар харин омгорхон бардамнаж элчийг барьж алсан ... мөхөс би дараа жил биеэр их цэрэг дайчлан ялыг чинь нэхэмжилнэ ²⁷ гэж сүрдүүлжээ.

²³ *Мин улсын судар*. Уг гэмдэглэл. I- XII боть УБ., 2018, 118.

²⁴ Мин улсын түүх. УБ., 2015, 21.

²⁵ 明太祖实录(Мин Тайзун шилү),永乐七年四月丁丑 (Юунлөгийн долоодугаар оны дөрвөн сарын улаагчин бар өдөр)

²⁶ Цзюсы. *Дунд гурван хилийн монгол ван тайж нарын намтар*. УБ., 2011,18.

²⁷ 明太祖实录(Мин Тайзун шилү),永乐七年七月癸酉 (Юунлөгийн долоодугаар оны долоон сарын харагчин тахиа өдөр)

Бунышири [Өлзийтөмөр] хаан ор сууж, найман он болоод ... 32 - ны барс жил [1410 он] нөгчвэй.²⁸ Мөн [Юунлөгийн 10 [1412] оны тэмдэглэлд Махаму Бун[я] ширийг довтлон хороов; Махаму зэрэгт алагдав; Махаму [Батула]... эзнийгээ хороосноо дуулга[н]²⁹ гэх мэт хятад сурвалжийн мэдээнээс үзвэл Бунышири 1410 -аад оны эхээр нэгэнт алагдан, улсаа нэгтгэн захирах оролдлого төгсгөл болжээ. Хожим монгол хэлний сурвалж зохиолуудын мэдээ зөрөөтэй, хаадын түүхийг он дараалуулан бичих гэж төөрөгдөж, хоёр хаан суусан улс төрийн ээдрээт байдлыг үүсгэдэг ч Бунышири [Өлзийтөмөр] хааны тухай Хураангуй алтан товч, Шар туужийн мэдээнд найман он ширээнд суусан хэмээсэн нь Бэшбалыгт гурван он, монгол нутагтаа ирж таван он болсныг зааж буй ажээ.

Ойрадууд хүчирхэгжсэн ч Монгол улсын хаан өргөмжлөх алтан ургийнхны ёс журмыг өөрчилж чадсангүй тул тэдний үр хойчсыг хаан сууринд залж, өвгөдийн нэр, алдар хүндээр нь улс орныг удирдахыг оролджээ. Монголд Батула чинсан Ойрад болон Монголын зарим хэсгийг, Төгстөмөр хааны хойчис хаад Монголын төв хэсгийг захирч, хоёр засаг тогтсоор байв. Ойрадууд Бунышири [Өлзийтөмөр] хааны хүү Дэлбэг (1395-1411-1415)-ийг³⁰ хаан өргөмжилж, улс төрийн бодлогодоо ашиглаж эхэлсэн. Аругтайн захидалд [1412 он] Махаму өөрийн эзэн Буныширийг алаад [шинэ хаан сууринд гаргав]³¹; Дэлбэгийг хаан болгов³²; Махаму өөрийн дураар Далбаг [Дэлбэгийг хаан өргөмжилсөн]³³ гээд Аругтай тайш, Бунышири[Өлзий төмөр] хааны өшөөг авч өгөхийг хүсч, Мин улсад хэд хэдэн удаа элч илгээн, энэ хооронд өөрийн хүчийг зузаатгаж байв. Ишбалдангийн Эрдэнийн эрих зохиолд Бунышири хаан Дай Мин улсын цэрэгт ялагдсаныг далимдуулан Ойрадын Махаму ... монголын хааны[г] хороож тамгыг булаан, Дэлбэгийг хаан суулгаж, эрх мэдлийг гартаа төвлөрүүлэн, хааны нэрийн өмнөөс Мин улстай харилцах болсон гэжээ.

Юунлөгийн 12 оны гурван сарын арван долооны цагаан барс өдөр [1414.04.06] ... [хуанди] биеэр зургаан замын цэргийг манлайлж Ойрадын зэрлэг дээрэм, Дэлбэг [хаан], Махмуд [Батула чинсан], Тайпин, Батболд нарыг дайлаар мордов. Морьт явган ноёд цэрэг тавин түм илүү байлаа³⁴ ... Таван сарын хорин дөрвөнд Хэрлэн

²⁸ *Хаадын үндсэн хураангуй алтан товч*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. VI. УБ., 2006, 84; Лувсанданзан. *Алтан товч*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. V. УБ., 2006, 32; *Эртний хаадын үндэслэсэн төр ёсны Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оривой*, Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал VII. УБ., 2006,62; Саган сэцэн. *Эрдэнийн товч*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. VIII. УБ., 2006, 285.

²⁹ *Мин улсын түүх*. УБ., 2015, 78, 22.

³⁰ Өлзийтөмөр хааны хүү Дэлбэг [Дэлбэ хаан, Далба хаан], Хөхөгчин гахай жил [1395 он]-тэй, Цагаагчин туулай жил [1411 он] 17 насандаа хаан ор сууж [зарим сурвалжид харагчин луу жил гэжээ], Хөхөгчин хонин жил [1415 он] хорин хоёр насандаа тэнгэр болжээ. Шар туужид Эсэхүд хороогдсон гэж тэмдэглэсэн байна. Буяндэлгэр түүнийг Арибөхийн угсааны гэж үзсэн.

³¹ 明太宗实录(Мин Тайзун Шилү), 永乐十一年六月己酉、庚午 (Юунлөгийн арваннэгэн оны зургаан сарын шарагчин тахиа өдөр, цагаан морь өдөр)

³² *Мин улсын судар*. Уг тэмдэглэл I-XII. УБ., 2018, 126. Мин улсын түүхэнд Юунлө (永樂) (1403 – 1424)-гийн X [1412], XI [1413]онд Дэлбэгийг хаан суусан тухай мэдээ бий.

³³ *Мин улсын судар*. Олон шаштир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 138.

³⁴ Мөн тэнд , 107.

гол хүрч ... зургаан сарын хорин[д] урт нь хэдэн арван газар нэгэн уулын хавцалд орж Шуанчоань (Хос булгийн нуур) нуурт буудаллав. Мин улсын түүхэнд зуны сүүл сарын хөх луу өдөр Ханхархай [нэрт газар] Батула чинсангийн гурван түмэн цэрэгтэй тулгарч, [галт буугаар дөрвөнтэй галлав ... дээрэм цөм ялагдаж, шархадсан морь хүний тоо тоолшгүй болов³⁵], шар бичин өдөр Хэрлэн голын дээд урсгал Хулан хошуунд ... Дэлбэг хаан болон Ойрадын ноёдын удирдсан цэрэгтэй тулалдан хан хүү 10 гаруй, аймгийн ард иргэд хэдэн мянган хүнийг алав ... мөшгөн хөөж, хоёр өндөр уулыг даваад Туул гол хүрэв. Махаму тэргүүтэн ... гарч дутаасан тул цэргийг эргүүлэв³⁶, ... Дэлбэг, Махмуд, Тайпин, Багболд нар тосон ирж байлдав. Дээрэмчид хуарангаас арван ли газарт дөрвөн хэсэг болон хуваагдан ууланд жагссан нь барагцаалбал гурван түм гаруй. Хүн бүр 2-3 хөтөлгөө морьтой...хятадын тал галт зэвсэг хэрэглэсэн тул ойрадуудын цэрэг ялагдсан³⁷ гэж дэлгэрэнгүй тэмдэглэжээ.

Батула чинсан ялагдаж, 1415 онд [хөхөгчин хонин жил] Дэлбэг хааныг Эсэхү³⁸ гар хүрч хороов гэж тэмдэглэсэн байдаг. *Ойрадай* (? -1415 -1425) хаан ширээ залгамжилж, эрх мэдэл Эсэхүгийн гарт төвлөрчээ. Эрдэнийн товч зэрэг түүхийн зохиолд ... хөхөгчин хонин жил [1415 он] Үгэчи хашихагийн хөвгүүн Эсэхү хаан ор сууж, арван нэгэн он болоод хөхөгчин могой жил [1425] жилээ егүүтгэвэй, Ойрадын Үгэчи хашихагийн хүү Эсэхү ... өөрийгөө хаан өргөмжлүүлжээ. Эсэхү, Батула чинсаны Самар гүнжийг [хатныг] авав гэжээ. Түүнийг бас Ойрадай хаан [Ойрадын хаан] хонин жил [1415 он] их ор сууж арван нэгэн он болоод могой жил [1425] тэнгэр болов, мөн нэг жил болоод тэнгэр болов гэж хожмын түүхчид өөр өөр мэдээ тэмдэглэсэн байдаг. Хэдийгээр сурвалжуудын мэдээ зөрөөтэй ч Үгэчи хашихагийн хүү Эсэхү нь Ойрадай хаан мөн эсэх; Аригбөхийн угсааны хүн үү; Дэлбэг хааны Ойрад хатнаас төрсөн бага насны хүү Ойрадайг хаан өргөмжилсөн гэдгийг тодруулах чухал ч баттай мэдээ баримт олсонгүй. Тэрээр эрх мэдлийг төвлөрүүлэхийг оролдсон ч баруун, зүүн монголын ноёд хүлээн зөвшөөрсөнгүй, хөрш Мин улсын түүхэнд ч дурьдсангүй.

Өмнө өгүүлснээр Ойрадад олзлогдсон Элбэг хааны Өлзийтгоо хатнаас 1400 оны орчим нэгэн хөвгүүн төрсөн нь *Өөдлөх Ажай* нэртэй. Хөвгүүнийг Ач тайж хэмээн нэр өгөв.³⁹ 1415[6] онд Самар хатан, Эсэхү үхэв [энэ нь таашаарсан болов уу, он цаг болоод, түүхийн үйл явдлыг харьцуулан үзвэл Батула чинсан үхэв,

³⁵ *Нанхиад сурвалж дахь монголын түүхэнд холбогдох ойлбор*. УБ., 2020, 113-114.

³⁶ *Мин улсын судар*. Олон шаштир. 328 дугаар дэвтэр. Ойрад. УБ., 2018, 209.

³⁷ Ариунгуа Н. *Монголын түүх ба Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд (XIV-XVI)* УБ., 2022, 80.

³⁸ Эсэхү бол Ойрадын Үгэчи хашиха мөн; Дөрвөн Ойрадын Үгэчи хашихагийн хүү Эсэхү, Өөлдөөс суусан хаан буй; Өөлдийн Хашихагийн хөвгүүн Эсэнхү; Хонда Минобу: Гүйлич бол Үгэчи хашиха мөн түүний хүү Эсэхү тул Аригбөхийн угсаа; Буяндэлгэр ... Ойрадай хаан Эсэхү биш, Эсэхү бол Мэргэн эрхэтү ван (Ки ван) Тайван юм. Тайван бол Торгуудын өвөг дээдэс. Үнэндээ Үгэчи хашихагийн хүү бөгөөд тухайн үеийн хаан Ойрадайгаас өөр хүн юм. Ойрадай бол Аригбөхийн угсааных агаад Махамуг Аругтайд алагдсаны дараа Эсэхү түүнийг хаан өргөмжилжээ. Магадгүй Саган эцэн хоёр хүнийг хутган ойлгосон ... Эсэхү бол Дэлбэг хааны хүү, Эсэхү бол Ажай тайж мөн, Ажай хааны өөр нэр, нэгэн үе Монголын төрийг барьсан Алтан ургийн хаан гэх мэт бүгд өөр өөрөөр бичдэг.

³⁹ Олноо өргөгдсөн хаанаас олон монголчуудад хэрэглэгдэх түүх. *Чингис хааны өв, соёл*. Боть II. УБ., 2021, 41.

Эсэхү төр булаав-Д.Э] Цэрэг авч ир хэмээн Өлзийтгоо бэйжийг хүү Ажайн хамт [төрхөмдөө] Монголд илгээв. Адай тайж, Өлзийтгоо бэйжийг авч гучин таван насандаа хаан орон сууж, Аругтайд тайш цол өгөв гэх мэдээ буй. Адай хаан гэгч хэн болох талаар сурвалжийн мэдээ бас зөрөөтэй. Чухам хэн Монголын хаан ширээнд сууж байсан нь ээдрээтэй. Хожмын түүхийн сурвалжуудад *Адай хаан, Атай тайж, Ажай тайж хаан, Ажай* гэж тэмдэглэн нэг хүн мэт ойлгох, үл ойлгох хандлага газар авч, хаан суусан он цагийн дараалуулан бичих гэж төөрөгдөлд хүрч байсан нь харагдана. Тэгвэл 1415-1416 оноос 1438 он хүртэл [Ойрадай (?-1415 -1425), Адай (?-1416-1438), Ажай тайж (1400-1426–1430)] урьдын адил нэгэн зэрэг хаан сууж байсан үе юм.

Мин улсын цэрэг Ойрадыг дайлж, Асуд аймгийн Аругтайд хүчирхэгжих боломж олгожээ. Тэрээр Асуд, Хорчин аймгуудыг өөрийн захиргаандаа оруулжээ. Монгол хаадын хэд хэдэн үе тасарч хаан төр доройтсон, Ойрадын ноёд өөр хоорондоо тэмцэлдэн хүч нь суларсан, Ойрадай хаан эрхийг авсан үед Юань улсын үр үндэс тасрав гэж 1416 онд Аругтай, Хасарын хойчис Арагтөмөрийг дэмжин, түүхэнд Адай⁴⁰ хаан хэмээн алдаршжээ. Перс хэлний сурвалжийн мэдээгээр үндэс болгон Минобу Хонда, Буянхүү, Жахачидай Буяндэлгэр нар түүнийг Гүйличийн хүү⁴¹; мөн Дэлбэг хааны хүү⁴² гэжээ. XVII зуунаас хойшхи монгол хэлний сурвалж зохиолуудын нэг Мэргэн гэгээний Алтан товчид Адайн хааныг Хасарын угсааны гэжээ, бид үүнийг баримтлав.

Адайн хаан суусан он цагийн талаар:

Хаадын үндсэн хураангуй алтан товчид ... хонин жил [1415 он] Ойрадай хаан их ор сууж, арван нэгдүгээр он могой жил [хар могой 1425 он] тэнгэр болов. Мөн могой жил Адай хаан их ор суув;

⁴⁰ Адай хаан (? -1416-1438)- ы удам гарлын тухай Хураангуй Алтан товч, Лу Алтан товч зэрэгт дурьдсангүй, Шар туужид ... Эзний үр Адай тайж Гангын урсгалд Дэлбэ Юнлэгийн есдүгээр онд [1411] тэнгэр болов. Мөн он түүний хөвгүүн Ойрадай хаан суув. Арван нэгэн он болж, Юнлогийн арванесдүгээр онд тэнгэр болов. Мөн онд түүний хөвгүүн Адай хаан; харин Эрдэнийн товчид Отчигин эзний үр Атай тайж; Алтан хүрдэн мянган хигээст бичигт Хавт Хасарын үрс ... Агсалдайгаас Аругтөмөр, Өрөгтөмөр хоёр ... Аругтөмөрөөс Агтаалаг, Түүнээс Жигү, Тоху, Жүсүнгү гурвуул. Тохугийн хөвгүүн Томулаху баатар хөвгүүн Хачи хүлэгтэн. Томулаху баатар Тогоонтөмөрийг Бээжингээс гарахуйд хятад цэрэгт алагдаж үхвэй. Жүсүнгүгээс Шигүшитэй баатар, энэ Адай хан; Ломигийн Монгол Боржигид овгийн түүхэнд Угсааны дүү Адай, Адай хаан Чингис хааны дүү хавт Хасарын үрс; Мэргэн гэгээний Алтан товчид ... Хасарын үрс ... *Болдбөхийн хүү Адай тайж* гэж тэмдэглэсэн. Японы эрдэмтэн Х. Минуба, Адай бол Өгөдэйн хойчис уг эзэмшил нь Ганьсу хязгаар байв гэжээ. Мөн түүнийг Гүйлэчийн хүү ч гэсэн санал байдаг. Адай хаан (?- 1416 -1438)- ы төрсөн он цагийг Саган эцэн ... Тэр Адай тайж улаан луу жилтэй [1376], Адай хаан цагаан морин жилтэй [1390] хэмээн хоёр өөр мэдээ уламжилсан. Мөн 1380, 1381 оны орчим төрсөн гэж үздэг.

⁴¹ Буяндэлгэр. XV зууны эхэн хагасын Умард Юань улсын хаадын угсаа залгамжлал ба төрийн байдал//ACTA HISTORICA MONGOLICA. Том XIX. F-66, УБ., 1919, 68-69.

⁴² Олноо өргөгдсөн хаанаас олон монголчуудад хэрэглэгдэх түүх. *Чингис хааны өв, соёл*. Боть II. УБ., 2021, 42.

Лувсанданзангийн Алтан товчид ... хонин жилд [1415 он] Ойрадай хаан их ор суув[арван] нэгдүгээр он могой жилээ [1425 он] тэнгэр болов. Түүний хойно могой жилээ [1425 он] Адай хаан ор суув⁴³ хэмээсэн нь Монгол хаадыг он дараалуулан бичих гэж Адайг 1426 оноос хаан суусан гэж ташаарсан бололтой.

Гомбожав Гангын урсгалд ... Дэлбэ Юнлэгийн есдүгээр онд [1411 он] тэнгэр болов. Мөн он түүний хөвгүүн Ойрадай хаан суув. Арван нэгэн он болж, Юнлогийн арван есдүгээр онд тэнгэр болов. Мөн онд түүний хөвгүүн Адай хаан... арван дөрвөн он суувай [буюу 1421 - 1436 онд хаан суусан гэж үзжээ];

Дарма гүүш ... Адай хаан 25 дахь хаан гэжээ.

Шар туужид ... Адай тайж Өлзийтгоо бэйжийг авч 35 насандаа хан ор сууж ⁴⁴ ... хэмээсэн ч төрсөн болон хаан суусан жилийг дурьдсангүй эргэлзсэн байна.

Саган сэцэн ... хөхөгчин хонин жилээ [1415 он] Үгэчи хасхагийн хөвгүүн Эсэхү нэрт ... хан ор сууж ... арван нэгэн он болоод ... могой жилээ [1425] егүтгэвэй. ... Тэр цагт Хорчин Отчигоны үр Адай тайж үлдсэн Монголыг эзэлж яван ажгуу. ... Адай хаан цагаан морин жилтэй [1390], 37 ны улаан морин жил [1426] хаан ор сууж 13 он болоод 49 ны шар морин жилээ [1438 он] Тогоон тайшид хороогдон халивай ... Тэр Адай тайж улаан луу жилтэй [1376 он] 35 ны цагаан бар жил [1410он] Өлзийт хунгоо бэйжийг аван Эзний өмнөөс хан ор сууж, Аругтайд тайш цол өргөөд⁴⁵ гэж хоёр өөр он жилийг дурьдсан нь бас эргэлзэж байжээ.

Асрагч нэртийн түүхэнд ... Хонин жилд [1415он] Ойрадай хаан их ор сууж, арван нэгэн он болоод могой жилээ [1425[6]он] нөгчвэй ... түүний хойно Адай хаан их ор сууж ...⁴⁶ хэмээн олонхи нь Адай хааныг 1426 онд хаан суусан гэж үзсэн.

Мэргэн Гэгээний Алтан товчид: Элбэгийн хөвгүүн Гүнтөмөр, Элтөмөр [Өлзийтгөмөр], Дэлбэй [Дэлбэг] гурав нь залган хаан болж, арван зургаан оныг [1400 - 1415 он –Д.Э] хүрвээс ... гурвуул үр үгүй нөгчин, хааны үр тасарсанд энэ улаан бичин жил [1416 он] Адай тайжийг хаан болгон өргөв⁴⁷ хэмээн Адай 1416 -1438 онд хаан суусан болохыг өгүүлжээ.

Хаан сууринд суусан улаан бичин жил [1416 он] Адай хаан (?-1416-1438), Ажай тайж, Аругтай тайш гурвуул цэрэг авч Бор нохойн зоо [Жалман хан] нэрт газар Ойрадуудтай байлджээ. Энэ тухай зарим сурвалжид могой жилд [1425[6] он] хэмээн бичсэн байх боловч, өмнөх хойтох үйл явдал Мин улсын түүхийн мэдээ зэрэгтэй харгуулан үзвэл 1415-1416 он байх нь хамгийн магадлалтай байна. Асрагч нэртийн түүх, Шар тууж зэрэг түүхийн сурвалж зохиолуудад

⁴³ *Хаадын үндсэн хураангуй алтан товч.* Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал.VI. УБ., 2002, 84-88, Лувсанданзан. *Алтан товч.* Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал.V. УБ., 2006, 238-240.

⁴⁴ *Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой.* Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. VII. УБ., 2006.

⁴⁵ Саган сэцэн. *Эрдэнийн товч.* Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. VIII. УБ., 2006, 108 -110.

⁴⁶ Жамба. *Асрагч нэртийн түүх.* Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. IX. УБ., 2006, 46-48.

⁴⁷ Мэргэн гэгээн Лувсандамбийжалцан. *Их Монгол улсын үндсэн алтан товч оршвой.* Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. XII. УБ., 2006, 77-78.

Адай хаан их ор сууж, урьд өшөөгөөр Ойрадад цэрэг мордов. Бор нохойн зоонд байлдахуйд цэргийн ирүүлд [халз тулаанд] Оннигудын Цагана түмэн [г] гар гэв. Адай хаан үрээ морь хурдан боловч хөгшин морь холч буй гэж Хавт Хасарын үр Шигүшидэй баатар он [ван] гурван давхар хуяг өмсч, элгэндээ хүрз хавчуулж, хонгор морио унаж ирүүлд гарав. Батула чинсангийн харьяат Хорилдой мэргэн [Гуйлинч баатар] гурван давхар дуулга өмсч хөх халзан морь унаж ирээд ирүүлд гарав. Шигүшидэй баатар, Хорилдой мэргэн хоёр урьдын цагт дайн тулаанд хамт явсан анд нөхөд билээ. Хорилдой мэргэн Их [ахмад] би ахалсу [эхэлье] гэж харвав. Эмээлийн урьд бүүрэг, гурван давхар хуяг, хүрзийг нэвт хойт бүүргэн дээр суутал харвав. Шигүшидэй:

Хонгор морины минь хошуу мэдтүгэй

Хотгор илдний минь ир мэдтүгэй

Төрд ёсны тул [төлөө] зүтгэхүйд

Төрөл ургаа ч үл таних [тал бүү хар] ... гэж найман талт давхар дуулгат толгойг сээр хүзүүнд хүртэл цавчив ... гэх.

1416 онд [Юунлөгийн XIV оны хаврын тэргүүн сарын хар барс өдөр] Аругтай тайш Ойрадыг ялсан тухайгаа Мин улсад мэдүүлж ... элч илгээн олзолсон хүн, малаа өргөжээ.⁴⁸ Ойрадай, Адай хаад эрх мэдлээ харилцан булаалдах болов. Бор нохойн зооны дайны дараа Улухуй мэргэн Батула чэнсянгийн хөвгүүн Бахамуг [Тогоон], эх Самар хатны хамт Адай хаанд хүргэжээ. Удалгүй Адай хаан Самар гүнж хатныг хүү Тогооны хамт Ойрадад буцаан Монгол, Ойрадын зөрчил намжсан ч энэ үеийн Монгол улсын дотоодын байдлыг

Монголын Аругтай тайш өтөлж

Аливаа үйл урсгал мэт санагднам.

Саадаг нь хувилж

Санаа нь эс хувилж

Төр мэдэх сайдаа гадна суулганам,

Зэвийн морио (байлдааны морио) гэр зуур унам

Өчүүхэн мэдэх хүнийг төрд явуулнам,

Үрээ морийг зэвлэм,

Босгуул хүнийг төр мэдүүлэм,

Борви хөхүүрт сархад хийнэм,

Буур үгүй тэмээ

Бух үгүй үхэр

Азрага үгүй адуу, Хуц үгүй хонь мэт ...⁴⁹ харилцан хаан ширээ булаацалдан, эрх мэдэл Аругтай тайшийн гарт шилжин төр улсын үйл цалгардах болсныг хожмын түүхчид шүүмжлэн өгүүлжээ.

⁴⁸ 明太宗实录(Мин Тайзун шилү),永乐十四年三月壬寅(Юунлөгийн арвандөрвөн оны гурван сарын хар бар өдөр)

⁴⁹ Лувсанданзан. *Алтан товч*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал.V. УБ., 2006, 240-241.

Мин улсын түүхэнд Ойрад, Мингийн дайнаас хойш жил гаруй болоод [1516 он] Махаму [Батула чэнсян] нас барав. Хүү Тохуань [Тогоон] залгамжлав⁵⁰; Ойрадын шаштирт дараа жил Ойрад, Аругтай лугаа байлдаж, ялагдан дутаав. Удалгүй Махаму үхэж ...⁵¹ гэж тэмдэглэжээ. 1418 онд Тогоон (1401[2]-1439) эцгийнхээ цолыг залгамжлахыг хүссэн⁵²; Юунлөгийн XVI [1418] онд Мин улсад Махамугийн хөвгүүн Тогоон элч зарж шан харамж, цол хэргэм олгохыг хүс[чээ] ... түүнд Шуннин ван [эцгийнх нь] цол⁵³олгожээ.

Ойрадай (? -1415-1425) хаан 1425, 1526 оны орчим үгүй болжээ. Тогоон байр сууриа бэхжүүлэх, Адай хаан (?-1416-1438), Аругтай тайшийн хүчийг сарниулах зорилгоор дахин нэг удаа довтолж, Мин улсын түүхэнд Шюаньдө (1425-1435)–гийн тэргүүн [1425] онд Аругтай ялагдан, Муна [өнөөгийн ӨМӨЗО-ы Иньшань уулын баруун тал] Цагаан нуурын хооронд дутаав хэмээн тэмдэглэжээ. Тогоон тайш тэндээс Ажай тайжийг хатад хөвгүүдийн хамт Ойрадад буцаан авчирсан. Тогоон болон Ойрадын ноёд 1426 онд Ажай тайжийг⁵⁴ Монгол улсын хаан өргөмжилжээ. Хархуушигийн хөвгүүн Ажай гал морин жилээс [1426 он] арван хоёр жил [хаан] суусан⁵⁵ гэжээ. *Ажай тайж хаан* (1400-1426-1430) Тодобуха, Агбаржин нэрт хөвгүүнтэй. Хаан суусан улаан морин жил [1426 он] Ойрад хатнаас [Мэргэн гэгээний түүхэнд монгол хатан гэжээ] нэгэн хөвгүүн төрснийг Мандуул хэмээн нэрлэв. Түүхэн цаг үе, үйл явдлаас үндэслэвэл мөн л хоёр хаан сууж, улс төрийн амьдрал ээдрээтэй хэвээр байв. 1427 онд Тогоон тайш, Аругтай тайш, Монголын хаан тус тус Мин улсад элч илгээжээ. Монгол, Ойрадыг харилцан өрсөлдүүлэх, хүчийг сулруулах, уламжлал ёсоор Монгол хааныг хүндэтгэх төрийн ёсны уламжлалын дагуу Мин улсаас хариу бэлэг барьж, Ван цзы [Шяо ванзы] - д нум, илд, хуяг дуулга нэмж шагна[жээ].⁵⁶ Хэнийг Шяованзы хэмээн нэрлэсэн нь бүрхэг. Түүхчид Хай Юй ши Ван цзы [Аг[д]ай] гэж үздэг ч Тогоон тайшийн дэмжлэгтэй хаан суурийг залгасан Ажай тайж хаанд (1400-1426-1430) мөн Шяованзы цол өргөсөн байхыг үгүйсгэх аргагүй, магадлах шаардлагатай. Мин улсын түүхэнд 1420 оны дунд үеэс Монгол хаадыг *Шяованзы* (小王子) хэмээн нэрлэх болжээ. Судлаачид бага ван [хаан], өчүүхэн хаан эрх мэдэл үгүй, бага, хүүхэд хаан, өчүүхэн хэмээх утгаар хэрэглэдэг. Шяованзы цолны талаар Жигачидай Буяндэлгэр, Монгол хаад өөрийн дээдсийн цолыг

⁵⁰ Цзюсы. *Дунд гурван хилийн монгол ван тайж нарын намтар*. УБ., 2011, 19; Мин улсын түүх. УБ., 2015, 79.

⁵¹ *Мин улсын судар*. Олон шаштир. 328 дугаар дэвтэр. Ойрад. УБ., 2018, 210.

⁵² 明太宗实录(Мин Тайзун шилү),永乐六年冬十月丙子,七年五月乙未、六月癸丑,十六年三月甲戌、四月甲辰(Юунлөгийн зургаадугаар оны өвлийн арван сарын улаан хулгана өдөр; долоодугаар оны таван сарын хөх нохой өдөр, дөрвөн сарын хөх луу өдөр; арван зургаадугаар оны гурван сарын хөх нохой өдөр, дөрвөн сарын хөх луу өдөр)

⁵³ Мөн энэ тухай Мин улсын түүх. 328 дугаар дэвтэр. Ойрадын шаштир. УБ., 2015, 79.

⁵⁴ Монгол түүхийн сурвалжид Ажай тайж гэх. Агваржин жононгийн хүү Харгучаг тайжийн Өлзийт гоо бэйжи –гээс 1400 оны орчим төрсөн Ажай тайж. Ажай тайж нь Тодобух [Тайсун], Агабаржин [Абаржин] Мандуул гурван хүүтэй.

⁵⁵ Тэнгэрийн заяат богд Чингис хааны домог оршвой. *Чингис хааны өв, соёл*. Боть I. УБ., 2020., 80.

⁵⁶ Мин улсын түүхэнд *Хай Юй ши Ван цзи [Шяо Ван цзы] Атай* хэмээн тэмдэглэсэн байдаг.

дахин хэрэглэж байсан ... Махагүргис, Лигдэн хаад өөрийгөө Чингис хаан гэдэг ... [харин] өчүүхэн хаадын цол гэж тайлбарласан нь итгэхүйеэ бэрх⁵⁷ гэжээ. Монголын түүхийн зарим сурвалж зохиолууд болон судалгааны бүтээлд Ажайг хаан хэмээн бичсэнгүй нь тухайн үед нэг л хаан байсан гэх түүх бичлэгийн уламжлалтай холбоотой. Окада Хэдихира⁵⁸ С.Вада⁵⁹ Монгол хаадын угсаа залгамжлалын талаар судалгаа хийсэн. Honda Minoru перс, монгол, хятад хэлний түүхэн тэмдэглэлүүдийг харьцуулсан ба тухайн үеийн хаан угсаа залгамжлалын тухай эдгээр бүтээлд Ажай тайж хаан (1416-1430)–ыг угсаа залгамжлалын хүснэгтэнд оруулаагүй⁶⁰, тэд засаглалын хямралаас үүдэлтэй хоёр хаан сууж байсан талаар дурьдсангүй. Харин

Ломигийн Монгол боржигод овгийн түүхэнд ... Нүгэчи хашиха Батула чинсанг алаад Ойрадын чуулган нийлэхүйд ... Ажай тайжийг хаан суулгая хэмээн хэлэлцэв. Ажай хэмээх хааны хөвгүүн буюу ...⁶¹;

Сүмбэ хамба Ишбалжир ... Тогоонтөмөрөөс хойшхи Монгол хаадын үе залгамжийг дурьдахдаа ... Билэгт, Усгал, Энх, Элбэг, Гүнтөмөр, Дэлбэг, Өлзийтөмөр гээд Харгуцаг, *Ажай*, Тайсун ...⁶² гэх мэт цөөн түүх сурвалжид дурьдсан байна.

Түүхэн бодит байдал, сурвалжуудын мэдээг үндэслэвэл Тогоон тайш алтан урагтны үр хойчис Ажай тайжийг хаан ширээнд өргөмжилсөн магадлал өндөр, энэ зурвас үеийн он цагийн зөрүү, түүхэн үйл явдлын цагаан толбыг нөхөх боломжтой юм. Нэгэн үед хаан сууж байсан Адай, Ажай хоёрыг нэг хүн мэт бичих, Ажайг хааны угсаа залгамжлалд дурьдахгүй байх нь түгээмэл. Мин улсын түүхэнд тэмдэглэгдээгүй бол хаан суугаагүй гэж ойлгож болохгүй юм.

Мин улс болон Ойрадын Тогоон жил дараалан Адай хаан, Аругтай нарыг довтолж, 1430 онд дахин дайлж, харьяат олон нь бутран сарнижээ.

1430–аад оны эхээр Ажай тайж хаан (1400 -1426 -1430) нас барсан⁶³, түүний хүү Тодобух [Тайсун] (1422 -1430/8-1452)⁶⁴ -ыг хаан ширээ залгамжлагч гэж

⁵⁷ Жигачидай Буяндэлгэр. Дөчин түмэн Монгол хэмээх нэрийдлийн үүсэл ирэл ба жич холбогдол бүхий хэдэн асуудал//*Хятад дахь монгол судлал* III. УБ., 2014, 191.

⁵⁸ H. Okada. Даян хааны өвөг дээдэс//*Сигагү сэтгүүл*. 75-8. Токио., 1966.

⁵⁹ Wada Sei. Умард Өнийн хаан угсааны тухай//*Ичимүра докторын 70 насны ойд зориулсан дорнод Азийн түүхийн өгүүлийн цуврал*. Токио., 1933.

⁶⁰ Honda Minoru. On the genology of the early Northern Yuan//*Ural-Altische Jahrbuster*, XXX,3/4,1958.

⁶¹ Ломи. *Монгол Боржигид овгийн түүх*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. XI. УБ., 2006, 50-52.

⁶² Сүмбэ хамба Ишбалжир. *Хутагтны орон, их хятад, төвөд хийгээд монгол оронд дээдсийн ном гарсан ёс Галбарвас мод хэмээх оршив*. УБ., 2017, 600.

⁶³ Цагаан нохой жил буюу 1430 он.

⁶⁴ Монголын түүхийн зохиолуудад Ажай тайжийн [Рашпунцаг, Дарма гүүш нар Адай [Ажай -Д.Э] хааны ахмад хөвгүүн] гурван хөвгүүний ахмад нь Тайсун хаан гэжээ. Саган сэцэн, Тайсун тайж шим (хар) бар [1422 он] жилтэй гэжээ. Хураангуй алтан товч, Лу алтан товч, Асрагч нэртийн түүх зэрэгт морин жил [1438 он]-д их ор суув; Саган сэцэн 18-ны шаргачин хонин жил [1439 он]; Гангын урсгалд 18 насандаа өөрөө хаан суув, Рашпунцаг хөхөгчин туулай [1435 он] жил;

зарлан, Тогоон улсын тайш өргөмжлөгдсөн. Тодобух нас балчир, Тогоон тайш Дөчин их хошуу [Монгол], Дөрвөн Ойрад⁶⁵ -ийн цэрэг, улс төрийн эрх мэдлийг төвлөрүүлжээ. Хожим нь Тодобух ч түүний сүр хүчинд тулгуурлан улс орноо нэгтгэн захирах талаар багагүй амжилт олсон. 1432 оноос Аругтай тайш, Урайнханы харуулын монголчуудыг дайлж Ляодуны хязгаараар нүүж суудаг болов ... Ляодунгаас алба барьдаг болов гэх зэрэг мэдээ нь монголын зүүн талд Аругтай тайш, Адай хаан (?-1416-1438) баруун талд Тогоон тайш, Тодобух [Тайсун] (1422-1430/8-1452) хоёр хаан бүхий хүчин харилцан өрсөлдсөөр байжээ ... Ёс төдий хоёр хаан [Обо эти хана играли чисто номинальную роль]⁶⁶ байсан гэж бичжээ.

Аругтай тайшийн гол тулгуур болж байсан Хасарын хойчсийн аймагт эвдрэл гарч Арагтөмөрийн [Адай хааны нэр гэж зарим нь үздэг] дүү Өрөгтөмөр, зүүн тийш түрж ирсэн ойрадуудын мэдэлд оржээ. Адай хаан, баруун өмнө зүгт шилжин Хатан голын Бор тохой, Эзнээ голд нутагла[жээ].⁶⁷ Энэ үеэс ус бэлчээр сайтай, зам харилцааны уулзвар Хатан голын Бор тохойд [хожмын Ордос] Монгол ноёд удаа дараа нэвтэрч Мин улстай харилцах болсон. 1434 онд Мин улсын магад хуульд Адай хааныг олноо дагуулан Гань Лян орчим очиж амь зууж, элч илгээн Мин улсын өмгөөлөлд орохыг хүсэж байна, Лянжөү, Ганьсү орныг довтлох санаатай байна⁶⁸ гэжээ.

[1434 оны 12 сард] Доржбай [Адай хааны сайд] Мин улсад элч илгээснийг Ганьсугийн Цэргийн ерөнхий захирагч Мин улсын засагт мэдүүлсэн нь ... Доржбай 3000 хүн дагуулан... Лянжөүгээс арав гаруй газрын зайтай сууж цэргийн амуу, хүнс нэгэнт тасарчээ. Ланьжөү ойролцоо зээгээ алдаж [олзлогдож], буцааж өгөхийг хүсэн байна⁶⁹ хэмээсэнд Мин улс Ланьжөүгаас булаасан хүмүүсээ буцаавал, зээг чинь буцаана⁷⁰ гэх хариу илгээжээ. Дараа жил 1435 онд Адай, Доржбай нар Тогоочийг элчээр томилж, морь бэлэг хүргэн хэлэлцээр хийхийг хүсчээ. Мин улс ... олноо дагуулан дагаар ирвэл, та нарыг урьдын адилаар үзнэ. ... [Даруй] дагаар ирвээс, буруугаа залруулах завшаан олгоно ... буруугаа мэдэж байгаад үл залруулбал мөхөс би хэдийгээр та нарыг бүгдийг амьд үлдээе хэмээн бодож байсан ч хууль ёсонд хэрхэн нийцэх билээ. Та нар бодолхийлж үз⁷¹ хэмээн сэрэмжлүүлсэн байна.

Дарма гүүш модон [хөх] барс жил [1434 он] хаан суув гэж тэмдэглэжээ. Тэгвэл Ажай тайж хаан эцгийнх нь дараа 1430 -аад оны эхээр Тогоон түүнийг хаан ширээ залгамжлагч гэж зарлаж, 1439 онд Монгол ноёдын хуралдайгаар хаан ширээнд албан ёсоор өргөмжлөгджээ. 15 он болоод мичин жил [1452 он] Горлодын Цэвдэний гарт тэнгэр болов гэх.

⁶⁵ *Ойрад Монгол түүхэнд холбогдох сурвалж бичгүүд*. I боть. УБ., 2000, 26.

⁶⁶ Покотилов Д.Д. *История восточных монголов в периодъ династии Минь. 1368 - 1634. по китайскимъ источникамъ*. СПб., 1893, 47.

⁶⁷ Буяндэлгэр, анх Бодьдарма ноён Бор тохойд ирж суусан гэжээ.

⁶⁸ 明宣宗实录(Мин Шюаньзун шилү),宣德九年七月丙申(Шюаньдөгийн есдүгээр оны долоон сарын улаан бичин өдөр)

⁶⁹ 明宣宗实录(Мин Шюаньзун шилү),宣德九年十二月己未(Шюаньдөгийн есдүгээр оныарванхоёр сарын шаргачин хонь өдөр)

⁷⁰ Мөн тэнд, 宣德九年十二月辛酉(Шюаньдөгийн есдүгээр оны долоон сарын цагаагчин тахиа өдөр)

⁷¹ 明宣宗实录(Мин Шюаньзун шилү),宣德九年十二月己未(Шюаньдөгийн аравдугаар оны нэг

Адай, Доржбай хоёул Гань Лян ойролцоо хилийн боомтын гадна сууж, зам харилцааг таслан, Ойрадын элч буцаж чадахгүй, хил хязгаар түгшүүртэй болжээ. Мин улсын түүхэнд 1435 онд [Шюаньдөгийн Х оны өвлийн тэргүүн сарын хар барс өдөр] Адайдорж [Адай, Доржбай] элч зарав. Өвлийн сүүл сарын хар хулгана өдөр Адайдорж Жин жөүгийн Жэньфань-д довтолсонд Хэйшань ууланд ялав ... Сүжүө-г довтлов, Жөнтун [Инзун] (1436 – 1449)-гийн тэргүүн онд [1436 он] цэрэг илгээн Адайдоржтай ... Ганьсу мужийн Пинчуаньд тулалдан нэхэн хөөсөөр Сү Үшань уул хүрч [алж олзолсон хүн маш олон], II онд Ниншя, Ганьсугийн ... боомтоос гарч Адайдоржийг дайла[в]⁷² гэх мэдээ тэмдэглэгджээ.

[1436 онд] Мин улс цэрэг илгээн Адай [нарыг] довтолжээ⁷³. 1437 оны хоёр сард Мин улс Ойрадын Тогоонд бичиг илгээн ... Татарын хулгай Бодидарма болон Адай, Доржбай нар булаан дээрэмдэж, миний хилийг түйвээж, зам харилцаа нэвтрэхгүй болгож, таны элч тэр даруй буцаж чадсангүй. Ван та ... дайлсан ч амжилтгүй байна гэж сонслоо. Мөхөс миний сайд нар цэрэг гаргаж тэднийг устгахыг хүсэж байна. Цэргээ дагуулан баруунаас хойш чиглэн [яв], Миний цэрэг хилийн дагуу явахаар тохиролцоё гэж Мин улс Ойрадтай холбоолон, Адай хааныг дайлах тухай өгүүлжээ. Мөн Адай хаанд бичиг илгээн ... буруугаа хүлээн дагаар ир. Эс бөгөөс бид цэргээр дайлбал чи харамсах болно⁷⁴ гэж сүрдүүлжээ.

1437 онд Адай, Доржбай нар Мин улсад дахин нэг удаа элч илгээн амьдрах арга үгүй болоод хил хязгаарыг довтолсон хэмээжээ. Адайн хүчийг дайлах тухай нэгэнт тохирчихсон Мин улс цаг хожихыг оролдож, булаан дээрэмдсэнийг уучилж болно, аймаг олныг нь хилийн ойролцоо оршин суухыг зөвшөөрнө, манай улсын хараат бол, нэр нөлөө зэрэг хэргэм бүхий ноёдыг томилж хэлэлцээ хийхийг тулгаж байв. Мин улсын болон Ойрадын цэрэг 1437 оны 10 сард Адайн хүрээг довтолжээ. 1438 оны зун дахин довтолж, Эзнээ голын Уланайд ялаад, Хэйчюань хүртэл нэхэн хөөж, Мин улсын цэрэг Их говиос мянган газар хол гарч зүүн, баруун талаас нь Тогоон тайш, Тодобух [Тайсун] хаан шахан довтолсоор Адай хаан хороогдож, 150 гаруй ноёд Мин улсад олзлогдсон.

Саган сэцэний түүхэнд ... эдүгээ Монгол улс эртний адил эх тэргүүн нь сандран ажгуу энэ дээр нь морилбоос саар үгүй авмуй хэмээн ... Адай хаан авлаж явахуйд морилж ... Саймучин, Саламучин гэх хоёр ойрад хүүхдэд зэв дүүрсэн саадаг юугаа бүслүүлж, өөрөө дөрвөн их хошуут сум дүүрсэн саадгаа агсаад гөрөөс агнаж явлаа. Төдий ойрад [ыг] таниад хөтөч хоёр хүүхэд урван одсонд хаан дөрвөн их сумаараа дөрвөн хүнийг унагаад буруулан зорчиж, эзний ордонд хорголон бүхийеэ зэр зэв үгүйеэ мөхүүлэн аж, барьж хориод⁷⁵ Адай хаан ... гучин долоон насандаа ор сууж

сарын хөх морин өдөр, арван сарын хар бар өдөр)

⁷² Мин улсын судар. Уг тэмдэглэл. I-XII дэвтэр. УБ.,2018,167-168.

⁷³ 明英宗实录(Мин Инзуншилү), 正统元年正月己卯 (Жөнтунгийн тэргүүн оны нэг сарын шаргачин туулай өдөр)

⁷⁴ 明英宗实录 (Мин Инзуншилү), 正统二年二月丙子 (Жөнтунгийн хоёрдугаар оны хоёр сарын улаан хулгана өдөр)

⁷⁵ Саган сэцэн. *Эрдэнийн товч*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. VIII. УБ., 2006,109.

арван дөрвөн жил болоод ... морин жил хороо[гд]сон. Адай хаан морин жилд Тогоон тайшийн гарт тэнгэр болов ⁷⁶ гэжээ.

Мэргэн гэгээний Алтан товчид ... Адай хаан улаан бичин жил [1416 он] -ээс эхэлж хаан болон хорин гурван оны [1438] шар морин жил хүртэл Ойрад бүгдийг өршөөн атал Тайсун, Агбаржинтан сууриныг яарч хурааж, Саймуужиныг тухираад Адай хааныг хороож, Тайсун хаан болон, Агбаржин жонон болон, Тогоон тайш болов ⁷⁷ гэжээ.

Мин улсын түүхэнд [1438 онд] Адай[г] довтлон Монь уул Цагаан нуур орчим мөхөөв ... Аругтай тайж үхэж, Адай Хэси [Эзнээ гол] руу зугагаад тодорхойгүй, Хай Юй ши Ван цзы Атайгийн монголчуудыг Цагаан хэрмийн дэргэд дийлэв. Чжэн тунгийн [Ин зун] (1436–1449) –ийн III [1438] онд ... тэднийг Улуунай газар бут цохиж, нэхэн хөөсөөр ... Ганьсу дахь Хэйшань уулын хавьд байдаг газар хүрч, цөлөөс гарч, хилээс 1000 ли зайтай газар баруун, зүүн талаас нь шахан довтлов ... олзлогдсон аймгийн удирдагчдын тоо 150 хүрэв ... Адай, Доржибай нар бууж өгөв. Удалгүй Тогтохбух Адайг баривчлан хороов ⁷⁸ гэжээ.

1438 онд Мин улсын элч Ойрадаас буцахдаа ... Татарын дээрэм Адай, Доржбай нар Тогтохбух хаанд алагдав. Баруун хойдын хязгаарт зовох зүйлгүй болжээ гэх мэдээг дамжуулсан байдаг.

Ийнхүү *Хоёр засаг* (двойное правительство)–ын үе төгсгөл болж, олон жил үргэлжилсэн хямралыг зогсоон, Тодобух [Тайсун] хаан улс орноо нэгтгэн захирах боломж бүрэлдсэн.

МАХАГҮРГИС ХААНЫ (1446-1454- 1464) ТУХАЙ СУРВАЛЖИЙН МЭДЭЭ

Монгол хаадын угсаа залгамжлалыг бүрхэгдүүлэх, он цагийн ялгаа зөрүү буй болгож буй нь Тодобух [Тайсун]-ны хүү Махагүргис (1446-1454-1464) хаанд холбогдох он цагийн зөрүү болдог. Эсэн тайшийн түшмэл Болай 1454 оноос Харчин аймгийг захиран, Алаг чинсанг довтлон хааны тамгыг аваад Тодобух [Тайсун]-ны хүү Махагүргис (1446-1454-1464)-ийг хаан⁷⁹ өргөмжлөн,

⁷⁶ Лувсанданзан. *Алтан товч*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. V. УБ., 2006, 242; *Эртний монголын хаадын үндэсний их шар тууж оршвой*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. VII. УБ., 2006, 64; Жамба. *Асрагч нэртнийн түүх*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. IX. УБ., 2006, 48.

⁷⁷ Мэргэн гэгээн Лувсанбалданжалцан. *Алтан товч*. Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал. XII. УБ., 2006, 77-78.

⁷⁸ *Мин улсын түүх*. УБ., 2015, 24.

⁷⁹ Тодобух [Тайсун] хааны бага хатан Самараас төрсөн хүү. Шар туужид Тайсун хааны бага хатан Самар тайхугаас төрсөн Мэрхүгис нэрт хөвгүүнийг долоон настай ... хан ор суулгаж Үхэгт хаан хэмээн нэрийдэж явтал найман насанд нь Доголон тайж хороовой., Саган сэцэн: Тайсун хааны өчүүхэн хатан Самар тайхугаас Мархүргис улаан барс жилтэй [1446] ... 7 настай хаан ор суулгаж [1453] 8 настай Доголон тайжид хороогдов. Рашпунцаг шаргачин могой жил [1449 он] тэргүүн он сууринд нэг жил суув найман гэжээ. Асрагч нэртнийн түүхэнд ... Махагүргис хаан ...[хөхөгчин] тахиа жил [1465 он], Хураангуй алтан товч болон Лу алтан товчид ... найман он болоод ...[хөхөгчин] тахиа жил [1465 он] нөгчив гэх. Түүний нэрийг түүх сурвалжид Мин

баруун гарын чинсан улмаар улсын тайшийн эрхийг өөрийн гарт төвлөрүүлсэн. Махагүргис хаан нас бага тул Самар тайху эх нь түүнийг [үхэр тэрэгт суулган мордож] цэрэг удирдан Хүнхүй, Завханаас Ойрадад довтолсон тухай монгол сурвалж бичигт домоглон өгүүлснээр *Үхэгт хаан* хэмээдэг. Мин улсын түүх зэрэг хятад сурвалжид Шяо Ванзы (小王子)⁸⁰ гэжээ. Мөн Маэркээр, Махагүргис, Үхэгт хаан бол нэг хүн гэж үздэг.

... Махагүргис Монгол улс(аа) хураамжлан бүхийд⁸¹; Мин улсын сурвалжид ... Монголын эл аймаг хэдийгээр тархай байсан ч Болай ван ... Шяованзы (小王子) [Махагүргис] хэмээн өргөмжилж, Монголын хүчин бадран боомтын доторхийг тунхаглав; Болай дахин Алагийг [Ойрадын Алаг чинсан] довтлон цохиод Тогтобухагийн хөвгүүн Маэркээр-ийг аварч [олж] хаан суулгаад, цолыг Шяованзы (小王子) хэмээв.⁸²

Анх 1420 -аад оны дунд үед Адай болон Ажай тайж хаадыг Сяованзы (小王子) хэмээн хятадын түүхэнд тэмдэглэсэн байдаг тухай өмнө өгүүлсэн. Мин улсын эхэн үед Хатан голын Бор тохойд том хотууд, харуулуудаас гадна 92 бага цааз, 375 харуулын цамхаг 35,000 цэрэг⁸³ суулган, хил хязгаараа хамгаалж байсан ч монголчууд тэр бүр довтлох аюулгүй, зардал чирэгдэл их хэмээх шалтгаанаар цэргээ дотогш шилжүүлж энэ хязгаар нутгийн талаархи бодлого суларч хил боомт эзгүйрчээ. Махагүргис хааны үед монголчууд говийн өмнө Хатан голын Бор тохойд нэвтрэн Ниншягаас Шаньси мужийн гурван боомтын нэг Пянтоугань хүртэлх ус, билчээр сайтай газарт нутаглажээ. Монголчууд Хатан голын Бортохойд нутаглах болсон нь дотоодын зөрчил тэмцэл, байгалийн ган гамшиг, зуд турхан, Мин улстай арилжаа худалдаа хийх зам харгуйд ойртох зэрэг олон шалтгаантай ч холбоотой. Аругтайн харьяат Бодьдарма, 1430 аад оны сүүлчээр Адай хаан, түүний харьяат Доржбай нар Хатан голын Бортохойд орж Мин улсыг довтолж байсан тухай өмнө өгүүлсэн. Мин улсад элч илгээн алба барих нэрээр арилжаа нэвтрэлцэхээр өвөлдөө өмнө тийш Хатан голын Бор тохой оронд очиж, хавар болохоор хойш буцна, энэ үеэс монголчууд говийн өмнө нутаглах болсон байна. 1450-иад оны дунд үеэс Махагүргис хаан, Болай тайш, Муулихай ван, 1450–иад оны сүүлчээр Алачу [Оручи буюу Уриаханы Хутагт шигүши] удаа дараа харьяат олноо дагуулан ирж суурьшин, нутгийн хүмүүсээр газарчлуулан довтолж, Мин улсын нэн түгшүүртэй хязгаар нутаг болжээ.

улсын түүх. Татарын шаштирт Маркөр, Маэркээр маш олон янзаар тэмдэглэж ирсэн. Мөн хятад сурвалжид Махагүргис хэмээх нэрээр ч тэмдэглэсэн байдаг. Мин улсын түүх. Татарын шаштирт Маркөр, Маэркээр, Шяованцзы гэжээ. Мөн Н Ариунгуа: Маркер гээд Махагүргис нэг хүн бололтой; Маркер болон Махагүргис нар хаан ор дараалан суусан Тогтобухын хөвгүүд бололтой (Ариунгуа Н. *Монголын түүх ба Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд (XIV-XVI)* УБ., 2022, 122-123) гэжээ.

⁸⁰ *Мин улсын түүх*. УБ., 2015, 25.

⁸¹ Ломи. *Монгол боржигид овгийн түүх*. Монголын түүхийн сурвалж бичгийн цуврал. XI. УБ., 2006, 62.

⁸² *Мин улсын судар. Олон шаштир*. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 146.

⁸³ *Мин улсын түүх*. УБ., 2015, 28.

1455 онд [Дайзун Жинтайн зургаан оны зургаан сар] Мархагүргис хаан Болай, Муулихай нар Мин улсад элч илгээсэн⁸⁴ тухай:

... Умардын Шяованзы (小王子) Махагүргис (麻儿可儿), Пирмухамад (皮儿马黑麻) Суругтанг (锁鲁檀), Пинчян Энх (平章昂克), Муулихай (卯那孩), Болой (孛罗)-гийн элч Хөхөмзэйч(可可宛者赤), Бандали (板达阿里) нарыг элчээр Бээжинд илгээж, морь тэмээ өргөв. Сонсоход Алаг чинсан Эсэнг алсны дараа Болай, Алаг[чинсан] ийг алж, эзэрхэх эрхийг олжээ. Эсэнгийн эх болон эхнэрийг олзолжээ⁸⁵ гэжээ.

Мин улс, нутаг газар хол, хүнс нийлүүлэх тохиромжгүй, өмнөх хаадын үеэс төмөр болон зэвсэг нийлүүлэхийг хориглосон зэрэг шалтгааныг дурьдан хүсэлтийг хүлээн авсангүй. Инзун дахин Мин улсын хуанди өргөмжлөгдөн, оны цолоо Тяньшүн [1457 он] тэргүүн он гэжээ. 1463 оны зургаан сард Болай болоод Махагүргис хаан, Манлай, Болунай, Уянтөмөр нарын [200 гаруй хүн]⁸⁶ элчийг Мин улс хүлээж авсангүй. Мин улсын хил хязгаарт цэрэг түшмэлийг нэмэх, бэхлэлт цайзыг байгуулж, утаат хот [тавцан]-ыг хэрэглэх зэрэг арга хэмжээг авч жил бүр тусгай түшмэл илгээн шалгаж байх зарлиг гаргажээ. 1460-аад оны эхээр Үхэгт хаан Махагүргис нас биеэнд хүрч хааны эрх мэдлийг өөрийн гарт төвлөрүүлж эхэлсэн. Инзун хуанди Тяньшүний VI онд [1463 он] явуулсан захидалдаа ... Махагүргисийг хойд “Их хаан” буюу кэхань гэж нэрийджээ. Өөрөөр хэлбэл хятад улс Махагүргис хаанд маш хүндэтгэлтэй хандсны илрэл бөгөөд түүнийг хаан ширээнд ёсоор суусан хэмээн үзсэнийх бололтой.⁸⁷

1464 оны хаврын эхэн сард Махагүргис хаан, Болай тайш, Мандуул [нар] Дөрөөтийг Мин улсад элчээр илгээн алба барив. Мин улсын магад хуульд ... *өчигдөр орчуулж гаргасан умардын Махагүргис хааны бичигт, тэд элч явуулж, алба барихыг хүсэж байна*⁸⁸ гэжээ. Монголын элчийн авч ирсэн монгол бичгийг Харь улсын бичиг орчуулах тэнхим (四夷馆) орчуулсны дараа дээш айлтгаж, элчийг боомтоор нэвтрүүлэх тэмдэг бичиг олгожээ. ... 1000 хүн, алба өргөх адуу 3000 байна гэж тэмдэглэжээ.

1460-аад оны дунд үеэс Махагүргис хаан, Болай тайшийн хооронд зөрчил үүсчээ. Мин улсын түүхэнд Тяньшүний зургаан [1462] онд Тогтобухын хүү Дашбалгас хотод очиж Болайг ална гэсэн мэдээг авсан ба⁸⁹, Маэркээр [Махагүргис хаан] дахин Болай лугаа өшөөлж алахыг завджээ. 1463 оноос

⁸⁴ *Мин улсын судар*. Олон шаштир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 147.

⁸⁵ Мин Дайзуншилү, 景泰五年十月甲午,六年四月戊戌 (Жинтайгийн тавдугаар оны арван сарын хөх морин өдөр; зургадугаар оны дөрвөн сарын шар нохой өдөр)

⁸⁶ 明英宗实录 (Мин Инзун [Тяньшүн]шилү), 天顺七年六月丁亥 (Тяньшүний долоодугаар оны зургаан сарны улаагчин гахай өдөр)

⁸⁷ Ариунгуа Н. *Монголын түүх ба Мин улсын үеийн хятад сурвалж бичгүүд (XIV-XVI)* УБ., 2022, 126, 129.

⁸⁸ 明英宗实录 (Мин Инзун [Тяньшүн]шилү), 天顺八年正月乙丑 (Тяньшүний наймдугаар оны хаврын эхэн сарын хөхөгчин үхэр өдөр)

⁸⁹ Буяндэлгэр. XV зууны эхэн хагасын Умард Юань улсын хаадын угсаа залгамжлал ба төрийн байдал//АСТА HISTORICA MONGOLICA. Tom XIX. F-66, УБ., 1919, 91.

хаан, тайшийн зөрчил хурцаджээ. Учир нь Болай тайш, хааныг үл тоон өөрийн нэрийн өмнөөс Мин улсад элч илгээх болсон. Махагүргис хаан Эсэн тайшийн [нагац Ашитөмөр] хүүтэй холбоо тогтоон, Болай тайшийн нөлөөг бууруулахыг санаархах болсон зэргээс үүдэлтэй. Сурвалж бичигт Болой тайш, Дологоныг турхиран Махагүргис хааныг хороолгосон; мөн өөрийн биеэр цэрэглэн ирж хааныг хороосон гэх мэдээ үлджээ. Алтан товч, Асрагч нэртийн түүхэнд тахиа жил [1465 он], хятад түүхийн мэдээг үндэслэвэл [Чөнхуа (成化)(1465 -1487)-гийн тэргүүн оноос өмнө] Махагүргис хаан нэгэнт таалал болжээ. Болай тайш 1465 оны нэг сард Бологчи тэргүүтэй элчийг [2194 хүн] Датунд илгээжээ. Энд Махагүргис хааны нэр харагдахгүй байна. Арав гаруй жил хаан суусан нь [Саган сэцэн, Шар тууж зэрэг зарим сурвалжид нэг он хаан ор суусан гэх нь түүнээс хойшхи хаадын түүх, он цагийг будиантай болгосон ташаа мэдээ юм] тодорхой байна. Монгол, хятад сурвалжийн мэдээг баримталвал арав, арван нэгэн жил хаан суусан нь тодорхой байна. Махагүргис хааныг нэг он хаан суусан гэх мэдээг баримтлан Моолон, Мандуул болон Батмөнх Даян хааны төрсөн болон, хаан суусан, тэнгэр болсон он тооллыг зөрүүтэй тэмдэглэдэг.

Мандуул хааны их хатан Мандухай, ноёд түшмэдийн хамт засаг төрийн бодлогыг зангидан Алтан ургийн хүү Батмөнхийг хаан сууринд залжээ. Баянмөнх Болох жононгийн хатан Шихэр хатнаас 1473 оны орчим төрсөн хүү⁹⁰ Батмөнхийг шаргачин гахай жил [1479 он]⁹¹ Чингис хааны цагаан гэрийн өмнө Монгол улсын хаан ширээнд залж *Амь нас нь бат, үйлс нь мөнх, явдал ёс нь сайн, Даяар бүгдийн эзэн болтугай* ⁹² хэмээн Батмөнх нэр, Даян хаан цол өргөмжлөн их ёслол үйлджээ.

⁹⁰ Алтан хааны туужид Батмөнх нэрт хөвгүүн [нь] нэгэн настай өнчрөн хоцорсон гэжээ. Ажай тайж хааны хүү, Тайсан хааны дүү Агабаржин жонон, түүний хүү Харагцуг хун тайжийн хатан Эсэн тайжийн охин Цэцэг хатнаас хар бичин жил [1452 он] төрсөн хүү Баянмөнх Болох жонон ажээ. Монгол, Ойрадын зөрчлийн улмаас эцэг эхээс өнчрөн хоцорсон түүнийг Мандуул хаанд хүргэж, жонон цолоор өргөмжлөгдөн Монгол улсын төрийн хэрэгт зүтгэж явжээ. Баянмөнх жононгийн хатан Шихэр нэрт хатнаас төрсөн хүү нь Батмөнх Даян хаан юм. Батмөнх Даян хааны төрсөн он түүхийн тухай: модон бичин, шар бич жил, хөх бичин [1464 он] жил, хар бич жилтэй гэх өөр өөр тэмдэглэсэн. Тухайлбал, Саган сэцэний түүхэнд хөх бичин [1464 он] жил төрсөн гэх [Баянмөнх, Шихэр хатан хоёр 1468 оны орчим урагласан бөгөөд үүнээс хойш Шихэр хатнаас хүү төрсөн гэх тул ташаа ажээ]. Хураангуй Алтан товчийн долоон настай [шаргачин] гахай жилд [1479 он] хан ор суулгавай хаан суусан гэх мэдээг үндэслэвэл 1473 оны орчим төрсөн болно. Д.Покотилов 1466 онд төрсөн гэдэг нь Мин улсын түүхэн сурвалжтай дүйж байна гэжээ. Покотилов Д.Д. История восточных монголовъ въ периодъ династiи Минь. 1368 - 1634. по китайскимъ источникамъ. СПб., 1893, 13.

⁹¹ Шар туужид Батмөнх модон бичин жилтэй, долоон насанд нь барс жилдээ [цагаан бар 1470 он] хаан суувай, Саган сэцэн Батмөнх хөх бич жилтэй [1464] гээд долоон насан дээр ... тэр цагаан бар жил [1470 он] Даяар улсыг эзлэх болтугай хэмээн Даян хаан нэрийдэв гэжээ. Харин Хураангуй Алтан товч, Лу Алтан товчид Даян хааныг долоон настайд *нь гахай жилд* [шаргачин] гахай жил [1479 он] хан ор суулгавай гэснийг одоо судлаачид баримталдаг болсон.

⁹² Жамба. *Асрагч нэртийн түүх*. Монгоын түүхэн сурвалж бичгийн цуврал. IX. УБ., 2004, 60.

Даян хаан засаг захиргааны шинэчлэлт хийж, хааны хот [нийслэл] өмнө тийш шилжин Цахарт төвлөрч Монгол, Мин хоёр улс элч солилцон алба барих, арилжаа худалдаа хийн улс төр, эдийн засгийн харилцаа тогтворжсон. Мин улсын судрын мэдээг үндэслэвэл, 1488 оны таван сард Даян хаан анх удаа элч илгээсэн тухай:

[Хунжы (1488–1505)-гийн тэргүүн оны зун]... Исмайл үхэж, халдан ирэгсэд дахин Шяованзы (小王子) хэмээн[э] бас Баянмөнх ван [Батмөнх хаан-Д.Э] гэгч бөлгөө гээд ...Умардын Шяованзы [Батмөнх Даян хаан -Д.Э] харьяат ноёдоо дагуулан Датун ойлорцоо [хилээс] 30 гаруй газрын зайтай байна. Булаан, дээрэмдэх шинжтэй ...Удалгүй бичиг илгээж, алба барихыг хүсэв. Үг үсэг нь омгорхог, биеэ Их Юань улсын хаан гэж байна⁹³... дээрмүүд [монголчууд] хил дээр ирж хариу хүлээж байна гэжээ. Мин улсын хаан ... хэрэв Монголын Шяованзы үнэхээр алба барих хүсэлтэй бол элчийг хил нэвтрүүлж, ёс журмын дагуу угтахыг гадаад дотоод хэрэг эрхэлсэн түшмэдүүдэд сонордуул, хэрэв алба өргөхөөр ирэхгүй бол хилийн бэхлэлтийг чангатгаж, дайтахад бэлэн бай ⁹⁴ гэж байв.

Монгол хааны гол хүч Цахарын нутаг, баруун тийш Бор тохой орчим төвлөрч хил хязгаарыг довтлох нь нэн түгшүүртэй тул Мин улс шаардлагыг хүлээн авч хоёр улсын элчин харилцаа сэргэжээ. Удаа дараа элч илгээж⁹⁵ тэр цагаас хойш Баянмөнх [Батмөнх] тэргүүтэн олонтаа алба барьж[ээ]⁹⁶. 1488 онд Мин улс түүний хүсэлтийг хүлээн авсны дараа зургаан сард Даян хаан 1530 элч, адуу 4930-ийг илгээж... 500 хүнийг Бээжинд очихыг зөвшөөрч бусдыг нь хил орчим үлдээж⁹⁷ алба барих нэрээр арилжаа хийжээ. 1488, 1490, 1491, 1492, 1498 онд Мин улсад илгээсэн элчийн тоо 6000 хүрч Монгол, Хятадын арилжаа албан [адуун зах], ардын [сарын зах], хувийн гурван хэлбэртэй, тусгай дүрэм журмын дагуу арилжаа нэвтрэлцэн хоёр орны харилцааг шинэ түвшинд гаргажээ.

[1490 оны хоёр сард] ... Умардын 1,100 хүн боомтоор нэвтэрч, 400 хүн хаанд бараалхана. Ойрадын 400 хүн боомтоор орж, 150 хүн хаанд бараалхана⁹⁸ гэж Даян хаан болон Ойрадын элчийн хамт хүлээн авахаар журам дүрэм тогтоосон байна. [1491оны хоёр сард] Баянмөнх хаан [Батмөнх], Ойрадын тайш Хурах (火儿忽)нар, Нү Ли (努力) нарыг элчээр илгээж алба бариулав. Энэ удаа 1500 хүн хилээр орж, 500 хүн Бээжинд очжээ.⁹⁹ Даян хаан 2,000-3,000 аас цөөнгүй элч илгээх болсон нь Тайсун хаан, Эсэн тайшаас хойш хоёр улсын элчин харилцааны хамгийн оргил үе байсан.

⁹³ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治元年五月乙酉 (Хунжыгийн тэргүүн оны [1488] таван сарын хөхөгчин тахиа өдөр)

⁹⁴ Мөн тэнд, зургаан сарын улаагчин тахиа өдөр.

⁹⁵ Мөн тэнд, найман сарын шаргачин хонь өдөр.

⁹⁶ *Мин улсын судар*. Олон шаштир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 159.

⁹⁷ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治元年六月癸卯(Хунжыгийн тэргүүн оны зургаан сарын харагчин туулай өдөр).

⁹⁸ 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治三年二月癸巳 (Хунжыгийн гуравдугаар оны хоёр сарын харагчин могой өдөр)

⁹⁹ 明孝宗实录(Мин Шяозун шилү),弘治四年二月乙丑、辛巳 (Хунжыгийн дөрөвдүгээр оны хоёр сарын хөхөгчин үхэр өдөр, цагаагчин могой өдөр)

Харин 1493 оноос [Хунжи (1488-1505)- ийн VI оны зуны дунд сарын улаан барс өдөр] Шяованзы (小王子) [Батмөнх Даян хаан] Ниншя-д халдан Хөтао [Бортохой орчмоор]-гоор нэг гарч ирэн, нэг үгүй болсоор хулгай дээрэм босов¹⁰⁰. Мин улсад элч илгээсэнгүй, булаан дээрэмдэх болжээ. Мин улсын түүхэнд элчин харилцаа тасарсан шалтгааныг барьсан бэлэг сэлтийг чамлаж арилжааг зогсоон, уулгалах боллоо гэж монголчуудыг буруутгасан байдаг. Хунжыгийн VI онд [1493] Даян хаан Ниншя, VIII онд [1495] монголчууд Ляодун, Гансу, Лянжөүгийн чиглэлд нэгэн зэрэг довтолжээ. IX онд [1496] Датун, Шюаньфү, Янсүйд; X онд [1497] Датунд ... довтлов. XI оны [1498] хаврын тэргүүн сард Даян хаан элч илгээж алба барих [арилжаа нээхийг хүссэн ч] бүтсэнгүй. Дайн тулаан олширч, Ляодунгаас Хатан голын Бортохой хүртэлх өргөн уудам нутагт монголчууд *хил хязгаарыг туйвээн гай зовлон*¹⁰¹ авчрах боллоо гэх мэт Мин улсын түүхийн мэдээ бий.

Хунжы (弘治) –гийн 17 [1504] оны гурван сард Даян хаан 6000 хүн томилон илгээсэн, элчийн авч ирсэн бичгийг он сар нь таарахгүй, соль хэмээн буцаажээ. Монголын элч ... өнгөрсөн жил алба барихаар тогтож, өргөх бичиг нэгэнт хийгээд байсан ч учир явдал бүтсэнгүй [арилжаа нэвтрэлцсэнгүй]. Хойд газар цаас олдоход хүчир учраас хуучин бичгийг хэрэглэв. Өөр санаагүй¹⁰² гэж тайлбарласанд Мин улс 2000 хүнийг оруулахыг зөвшөөрчээ. ... 2000 элчийг нийслэлд оруулах зөвшөөрлийг олгожээ¹⁰³... [ч] зургаан сард Монголын Шяованзы (小王子) [Батмөнх Даян хаан] Урианханы ноёдтой хамтран Датун¹⁰⁴ руу довтлон боомтын дотор оржээ. ... тагнуулчийн мэдүүлснээр [тэд] зам хуваан нийслэл хотын хамгаалалтын боомтыг довтолмой хэмээмүй. XVII [1504] оны арван сард монголчууд хүн малыг уулгалан дээрэмдсэнийг тоолж баршгүй ... Даян хаан 1505 онд Шаюньфүгаар довтлон 1615 хүн амь үрэгдэн, 1156 хүн шархдан, 6500 толгой мал [олзлон] хохирол учруулжээ.

Даян хааны цэрэг улс төрийн бодлого нэгдмэл хүчирхэг, 1509-1517 онд зүүн талд Ляодунгаас баруун тийш Хатан голын Бор тохой, Ниншя хүртэлх өргөн фронтоор монголчууд зав чөлөөгүй уулгалан сүрдүүлж байв. 1517 онд монголчууд Шюаньфү орчмын 20 гаруй бэхлэлт цайз, хот сууринг довтлон цөлмөж, Даян хаан 50 мянган морьт цэргээр Янхөд халдан Инжөүд Мин улсын цэргийг бүсэлжээ. Мин улсын хуанди өөрийн биеэр цэрэг авч мордон Янхө гол

¹⁰⁰ *Мин улсын судар*. Уг тэмдэглэл. XIII-XXIV дэвтэр. УБ., 2018; Мин улсын судар. Олон шаштир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 159.

¹⁰¹ *Мин улсын судар*. Уг тэмдэглэл. XIII-XXIV дэвтэр. УБ., 2018, 37-40; Мин улсын судар. Олон шаштир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 159.

¹⁰² 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治十七年三月壬午 (Хунжыгийн арвандолдугаар оны гурван сарын хар морь өдөр)

¹⁰³ *Мин улсын судар*. Олон шаштир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 161; 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治三年二月癸巳 (Хунжыгийн арвандолоодугаар он [1504] оны гурван сарын хар морин өдөр)

¹⁰⁴ *Мин улсын судар*. Олон шаштир. 327 дугаар дэвтэр. Татар. УБ., 2018, 161; 明孝宗实录 (Мин Шяозун шилү), 弘治十七年三月壬午 (Хунжыгийн арвандолдугаар оны гурван сарын харагчин хонь өдөр)

дээр хоёр өдөр шийдвэрлэх тулалдаан болжээ. Энэ тухай Мин улсын түүхийн Уг тэмдэглэлд:

Жөндө (正德) (1506 -1521)-гийн XII оны [1517] өвлийн тэргүүн сарын хар луу өдөр Шяованзы Янхө-д халдан Инжөү-г дээрэмдэв. Улаагчин хонин өдөр [хуанди] цэргээ захиран түүнтэй таван өдөр тулалдав. Цагаагчин гахай өдөр хулгай цэргээ татан дутаан Датунд буудаллав¹⁰⁵;

Татарын шаштирт ... Жөндө (1506 -1521)-гийн XII оны өвөл. Сяованзы 50 мянган морьт цэргээр Юйлинээс [Ордостой хил залгаа нутаг] довтлов. Ерөнхий жанжин Ван Сюнь Инжөүд бүслэлтэнд оров. [Мин улсын] Эзэн хаан өөрийн биеэр Янхэцэнд [Датуны бэхлэлтийн бүс дэх] хүрэлцэн ирж цэргийн жанжин нарыг хавсруулахаар хүч илгээв. Эрэгчин эмэгчинээ үзэх шийдвэрлэх тулаан болж, дайсан жаал ухрав. Дараа өдөр нь дахин довтолж, чэнь цагаас [өглөөний 7-9 цаг] ю цаг [17-19 цаг] хүртэл 100 гаруй удаа байлдав. Дайсан баруун тийш ухрав. Тэднийг Пинлу, Шожоу (Шаньси дахь Гурван боомтын бэхлэлтийн бүсд хамаарагдах газрууд орч.) хүртэл нэхэн хөөв. Хуй салхи босч, гэгээн цагаан өдөр эд юмс үл үзэгдэнэ. Эзэн хаан буцав. Улс даяар ялалтаа тунхаглан зарлах тухай зарлиг буулгав. Энэ үеэс эхлэн дайсан жил бүр хил уулгалах болсон ч гүнзгий цөмрөн орохыг аанай зүрхлэхгүй байв¹⁰⁶ гэж тэмдэглэсэн байдаг. Мин улсын хаадын түүхэнд Инжөүгийн ялалт, Инжөүгийн гавьяатныг тэмдэглэн тавин мянга илүү хүнийг дэвшүүлэн шагнав хэмээн бичдэг.

Хожмын монголын түүхийн зохиолуудад 1517 онд Даян хаан таалал болсон¹⁰⁷ гэж үздэг. Тэрээр Инжөүгийн тулалдааны үед шархадсан эсвэл таалал болсон байхыг үгүйсгэх аргагүй. Зарим сурвалжид 1504 болон 1543 онд тэнгэр болсон хэмээсэн нь ташаарсан ажээ. Мин улсын түүхэнд Бодь Алаг хааныг мөн л Сяованзы хэмээх тул хожмын судлаачид 1540 он хүртэл үйл явдлыг Даян хаантай холбон авч үздэг. Инжөүгийн тулалдааны дараа монголчууд нутгийн гүн руу шилжин, хил хязгаарыг довтлох нь саарчээ. Мин улсын түүхийн Уг тэмдэглэлд 1517-1420 он хүртэл, Олон шаштирийн Татарын шаштирт 1517-1525 он хүртэлхи монголтой холбоотой мэдээ, хааны үйл явдлыг тэмдэглээгүй байдаг. Д.Покотилов хил хязгаар нам жим болсон нь монголчуудын өөр зуурын хямрал тэмцэл гүнзгийрсэнтэй холбоотой гэж тайлбарласан ч дотоодын дайн дэгдсэн тухай баримт үгүй харин монголчууд дайны гарз хохиролыг даван туулах, шинэ хаан сонгох зэрэгт анхаарал хандуулж байсан.

Ийнхүү Хоёр хаан суусан түүхэн хэрэг явдал, Махагүргисын хаан суусан он цагийн зөрүү зэргийг магадлан, Эзэнт гүрний дараах үеийн МОНГОЛ ХААДЫН УГСАА ЗАЛГАМЖЛАЛЫГ доорхи байдлаар авч үзэж болно.

¹⁰⁵ Мин улсын судар. Уг тэмдэглэл. XIII-XXIV дэвтэр.УБ., 2018, 57.

¹⁰⁶ Мин улсын түүх.УБ., 2015, 34.

¹⁰⁷ Хураангуй алтан товчид Даян хаан 44 насандаа [1516 [7]] тэнгэр болов. Лу. Алтан товчид 37 жил хаан ор сууж[1516 [7]] 44 насандаа тэнгэр болов. Шар туужид 74 жил хан ор сууж, 80 насандаа туулай жил нөгчвэй. 74 жил хаан сууж 80 наснаа харагчин туулай жил [1543] тэнгэр болов гэжээ.

	Монгол улсын хаад	Төрийн эрхийг барьсан ноёд
1	Тогоонтөмөр Ухаант хаан (1320-1333-1370)	
2	Аюуширидара Билэгт хаан (1338-1370-1378)	
3	Төгстөмөр хаан (1349-1379-1388)	Зоригт хаан буюу Аригбөхийн удмын Есүгөр ноён (?- 1388-1391)
4	Энх хаан (?-1391/2 - 1394)	
5	Элбэг нийгүүлэгч хаан [Майдарбал] (1362 - 1394 - 1399)	
6	Гүнтөмөр хаан [Тогоон] (1377 - 1399 - 1402)	
7	Буняшири [Өлзийтөмөр]хаан (1379 - 1403 -1410)	Өгөдэй угсааны [зарим судлаачид Аригбөхийн удмын гэх] Гүйлэч ноён (? - 1402 - 1408)
8	Дэлбэг хаан (1395 - 1411 - 1415)	
		Ойрадай (? - 1415 -1425)
9	Ажай тайж хаан (1400–1426–1430)	[Хасарын угсааны] Адай (? - 1416 - 1438)
10	Тодобух [Тайсун] хаан (1422-1430/8-1452)	
		Ойрадын Эсэн тайш (1417[?]-1453 -1454)
11	Махагүргис хаан (1446 - 1454 - 1464)	
12	Моолон хаан (1437 - 1464/5 - 1466)	
13	Мандуул хаан (1426 -1467 - 1479)	
14	Батмөнх Даян хаан (1473 - 1479 - 1517)	
15	Бодь Алаг хаан (1504 – 1519 - 1547)	
16	Дарайсун Гүдэн хаан (1420 - 1548 -1557)	
17	Түмэн засагт хаан (1539- 1558 -1592)	
18	Буян цэцэн хаан (1555 - 1593 -1603)	
19	Лигдэн хутагт хаан (1592 – 1604 - 1634)	